



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2020 · 06 сар | Дугаар 19

ГАРЧИГ

- 2–3** Бодлогын нийтлэл
- 4–5** Зохицуулалтын мэдээ
- 6–7** ФАТФ–аас өгсөн үүрэг даалгаврыг 100% хэрэгжүүлж, саарал жагсаалтаас гарах нөхцөлийг бүрдүүллээ
- 8** Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн зохицуулалтын дүрэм, журам
- 9–10** Финтек ба регтек
- 11–17** Судлаачийн индэр
- 18** Танилцуулга
- 19** Санхүүгийн боловсрол
- 20** Хөрөнгө, оруулагч үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах өргөдөл, гомдлын судалгаа
- 21** Компанийн засаглалын олон улсын хандлага
- 22–25** Зах зээлийн мэдээ
- 26** COVID–19–ийн дэлхийн ядууралд үзүүлэх нөлөөллийн тооцоо
- 27–28** Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Засгийн газрын IV байр, Бага тойруу–3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- +976-51-264444
- press@frc.mn
- www.frc.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ФАТФ–ААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ 100 ХУВЬ ХЭРЭГЖҮҮЛЖ, СААРАЛ ЖАГСААЛТААС ГАРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЛЭЭ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН



Манай улсыг ФАТФ–аас 2019 онд “Саарал жагсаалт”–д оруулжээ. Үүнээс гарах, үнэлгээг ахиулах ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ?

ФАТФ–ын Ази, номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2017 онд Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд үнэлгээ хийж, Харилцан үнэлгээний тайланг хэвлэн гаргасан. Тус тайлангаар Монгол Улсыг эрсдэлтэй, үндэсний бодлого стратегийг, банкнаас бусад санхүүгийн салбарт эрсдэлийн үнэлгээ

хийгээгүй, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлээгүй, эрсдэлийн талаарх ойлголт туйлын чамлалттай түвшинд байна гэж дүгнэсэн. Түүнчлэн ФАТФ–ын техникийн зөвлөмж, Шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүдийг хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзсэн тул Монгол Улсыг өргөтгөсөн эрчимтэй хяналтад 2017 онд оруулсан.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улс 2019 оны 7 дугаар сард Ажиглалтын дараах тайланг ФАТФ–ын Үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтүүдийн хувьд тайлагнасан бөгөөд харин эрсдэлд суурилсан хяналт шалгалт, хэрэг шалган шийдвэрлэх, хөрөнгө хураан авах, санхүүгийн хориг арга хэмжээ зэрэг шалгууруудын үнэлгээг хангалтгүй гэж үзэж ФАТФ–аас 2019 оны 10 дугаар сарын 18–ны өдрийн хурлаараа стратегийн дутагдалтай орнуудыг жагсаалт буюу “саарал жагсаалт”–д оруулж, 4 шууд хэрэгжилтийг хангалтгүй гэж үзэн эдгээрийн хүрээнд 6 хугацаатай үүрэг даалгаврыг 2021 оны 5 дугаар сар гэхэд биелүүлж дуусгахаар өгсөн.

Ургэлжлэл 6–р нүүрт >>

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ДҮРЭМ, ЖУРМУУДЫН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох хуульд заасны дагуу банкнаас бусад санхүүгийн үйлчилгээ болох даатгал, үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны салбарын үйл ажиллагааг хянаж зохицуулахаас гадна зах зээлийн шинэ тутам үүсэх харилцаанаас шалтгаалан зохицуулалтын хүрээний шинэ үүргүүдийг хариуцах болсон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.

Ийнхүү хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.1, 6.3.2, 6.3.3–т тус тус заасан эрх хэмжээний дагуу тус Санхүүгийн зохицуулах хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай холбоотойгоор 2020 оны 3 дугаар сарын 11–ний өдрийн 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”–ыг батлан мөрдүүлж байгаа бөгөөд тус журмын бүтэц, агуулгыг энэхүү дугаараараа танилцуулж байна.

Ургэлжлэл 8–р нүүрт >>

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.




БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ТОКИО ХОТ БА ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨВ

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН РЕФЕРЕНТ Н.НАРАНТУЯА

Олон улсад санхүүгийн төвүүд ажилладгийн ачаар хөрөнгө оруулагчид хоногийн 24 цагийн аль ч үед үнэт цаасны арилжаанд оролцох боломжтой байдаг. Үүнийг бүрдүүлдэг нэгэн санхүүгийн төв нь Токио хот юм. Токио хотыг мөн бизнес эрхлэгчдийн уулзах цэг ч гэж нэрлэдэг.



“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн 15 дахь дугаараар уншигч танд “Япон улсын санхүүгийн зах зээлийн хөгжил”-ийн талаар хүргэсэн бол энэ удаагийн дугаараар Токио хот хэрхэн олон улсын санхүүгийн төвийг бий болгож, өдгөө 3-рт бичигдэх болсон талаар хүргэе.

Дэлхийн санхүүгийн төв болсон улс орнууд дундаас Япон улс нь дэлхийн хоёрдугаар дайны дараа үеэс эхлэн эдийн засгийн хурдацтай хөгжих загварыг боловсруулан хэрэгжүүлсэнээр Азийн анхны үсрэнгүй хөгжсөн улс болсноор өдгөө дэлхийд гуравдагч том эдийн засгийг бүрдүүлсэн. Ийнхүү Хятад, Энэтхэг болон Зүүн Өмнөд Азийн улс орнууд “Нисэж буй галууны цуваан загвар”-ын дагуу Япон улсын хөгжлийн загвараар замнаж байгаа нь бид ч суралцаж болох хамгийн ойрын жишээ юм.

Японы Засгийн газраас олон улсын санхүүгийн төв болох гараагаа 1980-аад оны санхүүгийн либералчлалын үед эхлүүлсэн ба Либерал ардчилсан нам нь урт хугацааны туршид уг алсын харааг баримтлан ажиллаж байна. Тухайлбал 2010 онд уг нам Засгийн

газрыг удирдаж байхдаа Япон улсыг Азийн санхүүгийн болон хөрөнгийн удирдлагыг удирдах төв болгох зорилтыг дэвшүүлэв. Уг зорилгод бизнес эрхлэх орчныг сайжруулж, санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлснээр хүрсэн ба компаниудыг өрсөлдөх чадвартай, өрхийн санхүүгийн хөрөнгийг илүү үр дүнтэйгээр ашиглах боломжийг олгосон. 2012 онд ерөнхий сайд Шинзо Абэгийн удирдлага дор дахин Засгийн газрыг удирдахдаа Азийн санхүүгийн төв болох зорилгоо үргэлжлүүлэн 5 жилийн дотор дэлхийн санхүүгийн төв болохоор дахин алсын хараагаа болгосон.

Ингэснээр Абэномиксын хүрээнд санхүүгийн төв болоход гурван төрлийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Нэгдүгээрт, гадаадын компаниудыг татаж, хөрөнгийн зах зээлээ идэвхжүүлэхийн тулд орлогын татварыг 38 хувь байсныг 2014 онд 35, 2015 онд 32, 2016 онд 29.97 хувь болгож бууруулсан. Хоёрдугаарт, улсын тэтгэврийн сангийн багцад эзлэх Засгийн газрын үнэт цаасны хувийг бууруулж, дотоод болон гадаадын хувьцааны хэмжээг нэмэгдүүлэв. Гуравдугаарт, Засгийн газраас Nippon Individual Savings Account (NISA)-г гаргаж, хувь хүмүүсийг хөрөнгөө хадгалуулахыг санал болгосон. 2016 онд Засгийн газар Токиог Азийн санхүүгийн төв болгох зорилгыг дахин дэвшүүлэн ажилласнаар урт хугацааны алсын хараа болж чадсан.

Япон улс нь бүс нутгийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах, амьдралын түвшинг нэмэгдүүлэхийн тулд нөөц хөрөнгөө санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, урт хугацаат хөрөнгө оруулалт болон шаардлагатай дэд бүтцийг санхүүжүүлэхэд ашигласан байна.

Түүнчлэн Токио хотын захирагчийн алба (Tokyo metropolitan government office) нь 2020 онд Токиогийн олимп болохтой холбоотой 2013 онд хотоо санхүүгийн төв болгох зорилгод нэгдэн, 2014 оноос хамтран ажиллаж эхэлсэн. Ингэснээр хотын захирагчийн албанаас гадаад хүмүүст амьдрах тав тух, бизнес эрхлэх ээлтэй орчныг

бүрдүүлэхэд зорин ажилласан.

Дэлхийн санхүүгийн төвийн индекс (Global Financial Center Index)–ийн үнэлгээгээр Токио хот нь 2007 оноос 2017 оныг хүртэл Нью-Йорк, Лондон, Сингапур болон Хонг Конгийн дараа орох дэлхийн 5 дахь том санхүүгийн төв байсан ба Нью-Йорк болон Лондонгийн хөрөнгийн биржийг гүйцэж түрүүлэхэд хол

зөрүүтэй байгаа аж. Уг индексийг бизнес эрхлэх орчин, хүмүүн капитал, дэд бүтэц, санхүүгийн салбарын хөгжил болон нэр хүнд гэсэн 5 хүчин зүйлд суурилан тооцдог. Токио хот нь хүмүүн капитал, дэд бүтцийн үзүүлэлтээрээ тавт, бизнес эрхлэх орчин, санхүүгийн салбарын хөгжлөөрөө зургаад, харин нэр хүндээрээ долоод эрэмбэлэгдсэн

байна. Харин 2020 онд Токио хот гуравт жагсжээ.

Дотоод орчны шинжилгээ: Японы санхүүгийн шинжээчид (CFA)–ийн нийгэмлэгээс Токио хотын санхүүгийн төв болсон байдалд дотоод орчны шинжилгээ хийснийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт. Дотоод орчны шинжилгээ

ДАВУУ ТАЛ	
Улс төр, эдийн засгийн тогтвортой байдал	Эдийн засаг, улс төрийн хувьд харьцангуй тогтвортой ба эрүүл мэндийн үйлчилгээ нь хүртээмжтэй, амьдрах орчин таатай.
Эрсдэлийн түвшин	Банкны салбарын эрсдэл улсын хэмжээнд сайн удирдагддаг ба гэмт хэрэг болон авилгал хяналтан дор байдаг.
Засгийн газрын нөлөө	Токио хот нь Дэлхийн банкнаас гаргадаг төрийн үйлчилгээний чанар, улс төрийн дарамт шахалтаас ангид байдал болон төрийн бодлогын хэрэгжилтийн чанарыг хэмждэг Хотын чинээлэг байдлын индексээрээ гуравдугаарт ордог.
Бизнес эрхлэх орчин	Тодорхойгүй байдлыг удирдаж чаддаг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас Японы эрсдэлийн удирдлагын түвшинг сайн ангилалд жагсаасан.
СУЛ ТАЛ	
Олон улсын нэр хүнд	Токио хот нь Европын орнуудаас илүү сайн санхүүгийн үйлчилгээний төвтэй. Үүн дээр олон нийтэд санхүүгийн үйлчилгээгээ таниулах маркетингийн үйл ажиллагааг сайтар хүргэх шаардлагатай.
Бизнес эрхлэх хялбар байдал	Токио хот нь Дэлхийн банкнаас гаргасан бизнес эрхлэх хялбар байдлын индексээр 189 улсаас 36–рт бичигддэг. Уг индекс нь 10 дэд индексээс бүрддэг. Үүнээс: <input type="checkbox"/> Жижиг хөрөнгө оруулагчдыг хамгаалах байдлаараа 36–д; <input type="checkbox"/> Гэрээний хэрэгжилтийг хангуулах байдлаараа 51–т; <input type="checkbox"/> Cross border trade 52–т; <input type="checkbox"/> Барилгын зөвшөөрөл авах байдлаараа 68–д; <input type="checkbox"/> Зээл авах байдлаараа 79–д; <input type="checkbox"/> Татварын удирдлагаараа 121–т.
Олон улсын зах зээлээс чадварлаг хүний нөөц татах байдал	Токио хот нь Дэлхийн авьяасын индекс болон Хүний хөгжлийн индексээрээ 6–рт жагсдаг.
Мэргэшлийн үйлчилгээ	Олон улсын мэргэшлийн үйлчилгээний байгууллага татах таатай орчин бүрдээгүй.

Эх сурвалж: Tokyo as an international financial centre, CFA Society Japan

Өдгөө Токио хотыг тэргүүний санхүүгийн төв болгох алсын хараанд хүргэхэд гурван зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон байна:

1. Эрсдэл өндөртэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх. Япон хүний мөнгөнд хандах зан төлөв нь хуримтлал үүсгэх дадал тогтсон ч эрсдэлээс зугтаах төлөвтэй тул хувьцаа, бонд худалдан авахаас илүү банкны хадгаламжид хөрөнгөө байршуулдаг. Иймд гадаадын хөрөнгө оруулагчдыг эрсдэлтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхэд Токио хот орчим дахь орлогын болон өв залгамжлалын татварыг Азийн улс орнуудтай өрсөлдөхүйц хэмжээнд бууруулах хөшүүрэг ашигласнаар хүрнэ гэж харжээ.

2. Японы финтекийн салбарыг хурдтайгаар хөгжүүлэх шаардлагатай.

3. Мөнгөний зах зээлийн хасах утгатай хүүгийн түвшинг зорилтот 2 хувьд хүргэх.

Япон улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хөгжлийг гүйцэж түрүүлдэг арга барилаас манай улс суралцах боломжтой, амьдралд туршигдсан сайн жишээ юм.

Улаанбаатар хотыг санхүүгийн төв болгох боломж нээлттэй, газарзүйн байршлын хувьд давуу талтайг өмнө нь дурдаж байсныг уншигч та санаж байгаа байх. Дубай хотын санхүүгийн төв болж үсрэнгүй хөгжсөн туршлага, түүний араас Африкийн Бахрайн улс олон улсын санхүүгийн төвийг хөгжүүлэн өдгөө хамгийн бага хэлцлийн зардалтай арилжаа явуулдгаа олон нийтэд зарлаж байна. Манай улс цөөн хүн амтай, эдийн


засгийн хөгжиж буй үе шатанд явж буй хэдий ч давуу талаа ашиглан олон улсын эсвэл бүс нутгийн санхүүгийн төв байгуулах боломж бидэнд бий.

Санхүүгийн төв байгуулснаар дагаад аялал жуулчлалын салбар хөгжих гарц боломж бий. Тухайлбал манай улсынх шиг тэсгим хүйтэн өвлийн улирлын онцлогийг тодотгон, цэлийн харагдах тал газрыг ая жуулчлалын бүс болгон хөгжүүлэн жуулчдад сурталчлахад санхүүгийн төвийг зорин ирж буй үйлчлүүлэгчид аялаад буцах хүслийг өвөртлөн ирэх болно. Мөсөн гулгуур, мөсөн хотхоныг хараад сэтгэл нь догдолж, Монголын хүйтэнд өөрийгөө сорьж байгаа, өвөл хэрхэн алчуур хөлдөхийг туршиж үзсэн “Монголын өвлийг мэдрэхээр гадаадын жуулчид ирэх дуртай” гэж хэлсэн Япон профессорын үг учиртай байлгүй.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

БАНКНЫ ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИЙН ЭРХ ОЛГОХ ЦАХИМ СУРГАЛТ БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан Даатгалын багц дүрэмд даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажилтан мэргэжлийн сургалтад хамрагдаж зах зээлд оролцох эрх авсан байхаар зохицуулсан байдаг.



Санхүүгийн зохицуулах хороо төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд мэргэжлийн холбоодтой “Сургалт зохион байгуулах гэрээ” байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд Банкны даатгалын зуучлагчийн эрх олгох сургалтыг Монголын Банкны Холбоотой хамтран цахим хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтад арилжааны 15 банкны 410 ажилтан 14 хоногийн хугацаанд цахимаар суралцлаа.

Энэ удаагийн сургалтын шалгалтыг тусгай тестийн цахим программаар авч, дүнг шалгалт дуусмагц оролцогчдод танилцуулснаараа онцлог байв. Эрх олгох шалгалтад 369 ажилтан оролцож 286 ажилтан тэнцлээ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ФАТФ-ААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ БҮРЭН БИЕЛҮҮЛЛЭЭ



Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас Монгол Улсыг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр стратегийн дутагдалтай

орнуудын жагсаалтад оруулж, 4 Шууд хэрэгжилтийн хүрээнд 6 үүрэг даалгаврыг өгсөн.

Энэхүү 6 үүрэг даалгавраас Санхүүгийн зохицуулах хороонд Шууд хэрэгжилт 3-ын хүрээний 2 үүрэг даалгавар болох 1) Санхүүгийн зохицуулах хороо болон бусад Санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулагчид байгууллагын эрсдэлийг ойлгож, эрсдэлийн түвшинд тохируулж хяналт шалгалтын давтамж, хамрах хүрээг тодорхойлох, 2) Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд тохирсон, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэл ногдуулахыг 2021 оны 5 дугаар сар гэхэд биелүүлэхээр үүрэг өгөгдсөн.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс дээрх үүргийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах талаар холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн анхны явцын тайлан, тодруулгыг ФАТФ-ын Олон улсын хяналтын бүлэгт 2020 оны 01 дүгээр сард хүргүүлж, БНХАУ-ын Бээжин хотод хийсэн хамгаалалтын үр дүнд “Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд тохирсон, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэл ногдуулах” даалгаврыг амжилттай биелүүлж, үнэлгээг ахиулж, гүйцэтгэлийг хангасан. ФАТФ-ын Хамтарсан бүлгээс банкнаас бусад санхүүгийн салбаруудад хийгдсэн ажлуудыг өндрөөр үнэлж, үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтыг банкнаас бусад санхүүгийн салбаруудад хийсэн түвшинд хүргэх даалгаврыг авсан. Уг даалгаврыг биелүүлэхтэй холбоотой Хорооноос шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлж, ФАТФ-ын Хамтарсан бүлэгт 2020 оны 5 дугаар сард тайлан, тодруулгыг хүргүүлж, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох байгууллагууд өгсөн даалгаврын биелэлтээ 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдөр цахимаар тайлагнаж, амжилттай хамгаалсан. Тухайлбал, Үл хөдлөх хөрөнгийн эрхийн зуучлалын салбар, үнэт чулуу, металл, алт мөнгөний арилжаа эрхлэгчдийн салбар ямар нэгэн зохицуулалтгүй явж ирснийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэл, зохицуулалт, хяналтад авч, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлж, 173 үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниас 61 компанид, 218 үнэт чулуу, металл эрхлэгчдээс 31 этгээдэд тусгай зөвшөөрөл олгоод байна.

Үндсэндээ Санхүүгийн зохицуулах хороо ФАТФ-аас өгсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлж, саарал жагсаалтаас гарах боломжийг бүрдүүлээ.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНООС СУДАЛГААНЫ УРДЧИЛСАН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооноос Үндэсний статистикийн хороотой 2019 оны 12 дугаар сард Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад шинээр нэмэгдсэн санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлагчид, үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг бүртгэлжүүлэх, нэгдсэн мэдээллийн санг бий болгох зорилгоор хамтын ажиллагааны гэрээг байгуулсан.

Үүний дагуу 2020 оны 4 дүгээр сард үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, бизнесийн регистрт бүртгэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх ажлыг нийслэл, нийт аймаг, дүүрэг, сумдыг хамруулан улс орон даяар Үндэсний статистикийн хорооны 175 гаруй албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр



зохион байгууллаа.

Үндэсний статистикийн хорооноос судалгааны ажлын урьдчилсан үр дүнг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох албан хаагчдад 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдөр танилцууллаа.

Дээрх этгээдүүдийг илрүүлэхээс гадна ФАТФ-ын стандарт буюу 20 сая төгрөгөөс дээших бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн /хийдэг/ этгээдүүдийг тодорхойлох, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг мөрдүүлэх тухай мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр түгээх, эрсдэлийн түвшинг асуулгаар үнэлэх зэрэг өндөр ач холбогдол бүхий судалгаа болсон гэж Санхүүгийн зохицуулах хороо үнэлж байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН СОРИЛТЫГ БОЛОМЖ БОЛГОХ БОЛОМЖТОЙГ ОНЦЛОЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан 2020 оны хамгийн анхны IPO буюу олон нийтэд шинээр гарч буй хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслолын ажиллагаанд оролцлоо. Энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга хэлсэн үгэндээ тэрээр “Дэлхий даяар тархаад буй COVID-19 цар тахал манай улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд сөрөг нөлөө үзүүлж, хөрөнгийн захын үзүүлэлтүүд унаж, бид томоохон сорилттой тулгарч



байгаа хэдий ч нөгөө талаараа хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулагчид сорилтыг боломж болгох бололцоо байгаа гэдгийг онцолмоор байна. “Бодь даатгал” ХХК нь үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргаж, анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэхээр шийдвэрлэсэн нь хөрөнгийн зах зээлд хувьцаа, бондоо гарган санхүүжилт татахаар төлөвлөж буй бусад аж ахуйн нэгжүүдийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлж, боломж бололцоо байгааг харуулсан үйл явдал болж байна” хэмээн онцолсон.

Банк, даатгал, хөрөнгийн зах зээл гэсэн санхүүгийн 3 үндсэн тулгуур салбарууд хоорондоо өрсөлдөж бус хамтран ажиллаж нийт эдийн засаг, санхүүгийн зах зээлээ хөгжүүлж байдаг. Даатгалын компани хөрөнгийн зах зээл дээр нээлттэй хувьцаат компани болж байгаа нь үүний нэг жишээ юм. Мөн Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолд банкны салбарыг эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй банкны тогтолцоог хөгжүүлэх ажлын хүрээнд банкны нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх талаар шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг бэлтгэхийг холбогдох эрх бүхий байгууллагуудад даалгасан. Ингэснээр банк, даатгал, хөрөнгийн зах зээлүүд харилцан уялдаатай хамтран ажиллаж, цаашид манай улсын санхүүгийн салбарыг эрүүл, ил тод, тогтвортой өсөлттэй болгох нөхцөл бүрдэх юм.

“Бодь даатгал” ХХК-ийн үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргаж хувьцаат компани болох үйл ажиллагаанд андеррайтерийн компаниар “Би Ди Сек ҮЦК” ХК, аудитын компаниар “БДО Аудит” ХХК, хөрөнгийн үнэлгээний компаниар “Гэрэгэ Эстимэйт” ХХК, хуулийн компаниар Өмгөөллийн “ИЭлСи” ХХН нар тус тус ажиллажээ.



БАЙР СУУРЬ

» Эхлэл 1-р нүүрт

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ФАТФ-ААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ 100 ХУВЬ ХЭРЭГЖҮҮЛЖ, СААРАЛ ЖАГСААЛТААС ГАРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЛЭЭ

Монгол Улс “Саарал жагсаалт”-аас гарахад төрийн байгууллагуудын оролцоо, хүчин чармайлт чухал. Тэгвэл Санхүүгийн зохицуулах хороонд ямар төрийн чиг үүрэг нэмэгдэх болсон бэ?

ФАТФ-аас өгсөн үүрэг даалгавруудыг биелүүлж ажиллахад төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа нягт, уялдаа холбоо хамгийн чухал байсан бөгөөд үүний үр дүнд бид өмнөө тавьсан зорилгоо биелүүлээд байна. Санхүүгийн зохицуулах хорооны хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл, Терроризмтой тэмцэх зөвлөлийн гишүүнээр ажилладаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, хяналтыг сайжруулах, хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороонд нэлээдгүй ажил, чиг үүргүүд нэмэгдсэн. Тухайлбал, УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж, үл хөдлөх эд хөрөнгө зуучлагч, үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалт, хяналтад оруулж, тэдгээрийг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхээр зохицуулсан. Түүнчлэн ФАТФ-ын стандарт, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагуудыг биелүүлж ажиллах тухай хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Эдгээр 2 салбарын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх, холбогдох нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам, зааврыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, тухайн салбарыг бүртгэлжүүлэх, зөвшөөрөл олгоод зогсохгүй тэдгээрийн салбарын эрсдэл,

үндэсний эрсдэлийн үнэлгээ болон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт шалгалт хийх, сургалт семинар, соён гэгээрүүлэх ажил гээд цаг хугацаа шаардсан их ажлууд хийгдэж байна.

Санхүүгийн зохицуулах хороонд ямар үүрэг өгсөн, үүргийг хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээг авч, ямар үр дүнд хүрээд байна вэ?

Дээрх 6 үүрэг даалгавраас Санхүүгийн зохицуулах хороонд Шууд хэрэгжилт 3-ын хүрээний 2 үүрэг даалгавар болох 1) Санхүүгийн зохицуулах хороо болон бусад Санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулагчид байгууллагын эрсдэлийг ойлгож, эрсдэлийн түвшинд тохируулж хяналт шалгалтын давтамж, хамрах хүрээг тодорхойлох, 2) Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд тохирсон, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэл ногдуулахыг 2021 оны 5 дугаар сар гэхэд биелүүлэхээр үүрэг өгөгдсөн.

Санхүүгийн зохицуулах хорооноос ФАТФ-ын өгсөн даалгавруудыг нэн даруй хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг шуурхай хангаж ажиллалаа.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс дээрх үүргийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах талаар холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн анхны явцын тайлан, тодруулгыг ФАТФ-ын Олон улсын хяналтын бүлэгт 2019 оны 12 сар, 2020 оны 01 дүгээр сард хүргүүлж, БНХАУ-ын Бээжин хотод хийсэн хамгаалалтын үр дүнд “Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд тохирсон, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэл ногдуулах” даалгаврыг амжилттай биелүүлж, үнэлгээг ахиулж, гүйцэтгэлийг хангасан. Энэхүү авч хэрэгжүүлсэн арга хэмжээг ФАТФ-ын Хамтарсан бүлгээс өндөрөөр үнэлж, ФАТФ-ын 02 дугаар сард Франц улсын Парис хотноо болсон өндөр дээд хэмжээний хурал дээр богино хугацаанд амжилттай ажилласныг цохон тэмдэглэсэн бөгөөд үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр

хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтыг банкнаас бусад санхүүгийн салбаруудад хийсэн түвшинд хүргэх даалгаврыг авсан. Уг даалгаврыг биелүүлэхтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлж, ФАТФ-ын Хамтарсан бүлэгт 2020 оны 5 дугаар сард тайлан, тодруулгыг хүргүүлж, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох байгууллагууд өгсөн даалгаврын биелэлтээ 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдөр цахимаар тайлагнаж, амжилттай хамгаалсан.

ФАТФ-аас 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдөр албан ёсны мэдээг ирүүлж, Монгол Улсыг “саарал” жагсаалтад оруулах болсон шалтгаан буюу 6 үүрэг даалгаврыг бүрэн биелүүлснийг мэдэгдэв. Иймд Санхүүгийн зохицуулах хорооны хувьд 2019 оны 10 дугаар сарын 18-наас хойш 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл буюу 6 сарын хугацаанд шуурхай ажиллаж, өгсөн үүрэг даалгаврыг боломжит хамгийн богино хугацаанд бүрэн биелүүлж дууслаа. Өмнө нь Монгол Улсыг ФАТФ-ын саарал жагсаалтад 2011 онд оруулж, 2014 онд гарч байсан билээ. “Саарал” жагсаалтаас гарах нөхцөл бүрэн хангагдсан учир Санхүүгийн зохицуулах хорооноос ФАТФ-ын Хамтарсан бүлгээс ирэх газар дээрх шалгалтад бэлтгэх ажилд бэлтгэж ажиллаж байна.

Үндсэндээ Санхүүгийн зохицуулах хороо ФАТФ-аас өгсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлж, саарал жагсаалтаас гарах боломжийг бүрдүүллээ.

Дээрх үр дүнгээс харахад та Санхүүгийн зохицуулах хорооны даргаар томилогдоод удаагүй ч богино хугацаанд нэлээдгүй ажлуудыг амжуулаад байгаа юм байна. Та саарал жагсаалтад орсноос хойш мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ямар арга хэмжээ авч ажилласан талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга миний бие 2019 оны 12 дугаар сард Ерөнхий

сайдын захирамжаар байгуулагдсан ФАТФ-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас Монгол Улсыг гаргах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах чиг үүрэг бүхий ажлыг хэсэгт ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын хүрээний банкнаас бусад санхүүгийн 4 салбар, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийн 2 салбар буюу нийт 6 салбарт мөнгө угаах эрсдэлийн үнэлгээг амжилттай хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос Үндэсний статистикийн хороотой 2019 оны 12 дугаар сард хамтын ажиллагааны гэрээг байгуулж, үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, бизнесийн регистрийн санд бүртгэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх ажлыг Монгол Улсын бүх аймаг, сум, дүүрэг, нийслэлийг хамруулан улс орон даяар авч хэрэгжүүлээд байна. Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч этгээдүүдийг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, шинэ зохицуулалтын талаар мэдээлэл түгээх зорилго бүхий уг ажлыг Үндэсний статистикийн хорооны 175 гаруй албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр анх удаа авч хэрэгжүүлээд байна.

Мөн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн ажлыг хариуцсан тусгай алба болон Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч, үл хөдлөх эд хөрөнгө зуучлагчдын бодлого зохицуулалт, бүртгэл зөвшөөрөл, хяналт шалгалтыг хариуцсан газар байгуулсан. Санхүүгийн зохицуулах хорооноос Азийн хөгжлийн банкны Техникийн туслалцааны хүрээнд мөнгө угаах болон терроризмтой тэмцэх чиглэлээр арга зүйн туслалцаа дэмжлэг, зөвлөмж авах, зохицуулалттай санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан анхны сургалтыг

амжилттай зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээр үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангуулахаар нэр бүхий 4 журмыг баталж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг эрчимжүүлж ажиллаж байна. 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөр байдлаар нийт 182 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас тусгай зөвшөөрөл хүссэн баримт бичгээ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн бөгөөд 91 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад тусгай зөвшөөрөл олгож, 91 материал хянагдаж байна. Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн хувьд одоогийн байдлаар нийт 332 хүсэлт ирсэн бөгөөд 115 этгээдэд тусгай зөвшөөрөл олгож, 217 материал хянагдаж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн системийг уг гэмт хэрэгт өртөх эрсдэлийг бууруулахад санхүүгийн салбарт орж ирэх оролцогчдыг хянах ажлыг эрчимжүүлэх, гарал үүсэл нь тодорхойгүй, хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого, мөнгө угаах зорилготой этгээдийг санхүүгийн системд нэвтрүүлэхгүй байхтай холбоотой зохицуулалтыг хийж тохиромжтой этгээдэд тавигдаг шаардлагыг журамласан, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр зайны болон газар дээрх хяналт шалгалтын тухай журмуудад холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг ажлуудыг хийсэн.

Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн болон санхүүгийн бус 6 салбарыг тусгай зөвшөөрөл, бүртгэл, бодлого зохицуулалтаас гадна мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг

хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэл, тусгай зөвшөөрөлтэй этгээд болон олон нийтийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо хэрхэн ажиллаж байна вэ?

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай этгээдүүдийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, чадавхжуулах зорилгоор зохицуулалтын салбарын нэр бүхий 10 гаруй мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сургалт зохион байгуулах, сургагч багш бэлтгэх, олон нийт болон зохицуулалттай этгээдүүдэд зориулсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх видео бичлэг, шторкуудыг бэлтгэж, олон нийтэд хүргэж ажилласан.

Үүнээс гадна төрийн эрх бүхий байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээллийн урсгал, уялдаа холбоог сайжруулахаар Үндэсний статистикийн хороотой хамтран ажиллаж, улс орон даяар үйл ажиллагаа явуулдаг үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг илрүүлэх, ФАТФ-ын стандартад хамаарах этгээдийг эдгээрээс тодорхойлох, МУТСТ чиглэлээр хүлээх үүргийг таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна.

Монгол Улс 2020 онд Үндэсний эрсдэлийг үнэлэх ажлыг Дэлхийн банкны аргачлалд суурилсан зохион байгуулж байна. Уг ажилд Санхүүгийн зохицуулах хороо өөрийн зохицуулалтын бүх салбаруудыг хамруулан идэвхтэй ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.

Ярилцлага өгсөнд танд баярлалаа. Таны цаашдын ажилд амжилт хүсье.



ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

» Эхлэл 1-р нүүрт

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ДҮРЭМ, ЖУРМУУДЫН ТАЛААР

ЖУРМЫН БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам” нь дараах харилцааг зохицуулсан:

- 1 дүгээр бүлэгт журмын зорилго, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагаа, үйлчилгээний төрлийг тодорхойлсон;
- 2 дугаар бүлэгт үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл, шаардлага, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын мэргэжлийн боловсон хүчинтэй байх, уг үйл ажиллагааг эрхлэн явуулах тохиромжтой удирдлагын багтай байх, ажлын байр, тоног төхөөрөмж, санхүүгийн чадамжтай байх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зарчмуудыг тусгасан.
- 3 дугаар бүлэг нь тус журмын 2 дугаар бүлэгт заасан тусгай зөвшөөрлийг олгох,

олгохоос татгалзах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсан бөгөөд эдгээр шийдвэрийг гаргах үндэслэлийг тусгасан.

- 4 дүгээр бүлэгт тухайн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой холбогдох зөвшөөрөл авахад тавигдах шаардлага, зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл, хүчингүй болгох харилцааг зохицуулсан ба зөвшөөрлийн төрөлд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, салбар байгуулах, оноосон нэр өөрчлөх асуудлыг хамруулсан.

[/5 дугаар бүлгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/](#)

6 дугаар бүлэгт тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох бүртгэлийн төрөл, бүртгүүлэхэд тавигдах шаардлага, бүртгэхээс татгалзах үндэслэл зэргийг тодорхойлсон. Бүртгэлийн төрөлд тухайн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын нэмэлт үйлчилгээ эрхлэх, мөн эрх бүхий албан тушаалтан, брокер, агент, хаягийн

өөрчлөлтийг тус тус хамруулсан.

7 дугаар бүлэгт журмын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчсөн тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад хариуцлага тооцох зохицуулалтыг тусгасан болно.


Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэн явуулсан тохиолдолд хувь хүн, хуулийн этгээдийг Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авч, торгох шийтгэл оногдуулах зохицуулалттай байдаг.

Иймд Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй хуулийн этгээдүүд нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд цахим болон цаасан хэлбэрээр хандаж шийдвэрлүүлэх боломжтой.



ФИНТЕК БА РЕГТЕК

Зураг. Сүптекийн хэрэглээ



Эх сурвалж: Олон улсын төлбөр тооцооны банк

СҮПТЕК (SUPTECH) БУЮУ ХЯНАЛТЫН ТЕХНОЛОГИ

Технологи санхүүгийн үйлчилгээний салбарыг өөрчилж байгаатай ижлээр салбарын зохицуулалтад ч шинэчлэлтийг нэвтрүүлээд байгаа билээ. Хяналт, зохицуулалтын байгууллагууд үйл ажиллагаандаа хиймэл оюун ухаан, машин сургалт зэрэг технологийн дэвшлүүдийг ашиглахыг сүптек (SupTech = Supervision + Technology) гэдэг.

Сүптекийн гол зорилго нь зохицуулалтын байгууллагуудын ачааллыг бууруулж, тайлагнал, хяналтын тогтолцоог сайжруулах юм. Ингэснээр цаашдаа хяналтын системд нөөцийг үр ашигтай хуваарилан, зардлыг бууруулна. Жишээлбэл машин сургалтыг ашиглан ажилладаг сүптекийн хувьд дутуу, алдаатай, буруу өгөгдлийг илрүүлж, тэдгээрийг цэвэрлэх, баталгаажуулах үйл явцыг автоматжуулах боломжтой.

Олон улсын төлбөр, тооцооны банк (BIS)–аас сүптекийг мэдээллийг цуглуулах болон дүн шинжилгээ хийх гэж 2 ангилж үзсэн байна.

Тайлагнал: Мэдээлэл цуглуулах төрлийн сүптек нь бодит цагийн хяналт болон автоматжуулсан тайлангийн тогтолцоо мөн виртуал тусалцаа, мэдээллийг нэгтгэх, баталгаажуулах зэрэг зориулалтаар ашиглагддаг. Тус төрлийн сүптекийг

ашигладаг зохицуулагч байгууллагын нэг жишээ нь Австрийн төв банк (OeNB) юм. OeNB нь зохицуулалттай байгууллагуудын мэдээллийн систем болон өөрсдийн мэдээллийн системийн хоорондын платформыг үүсгэснээр банкнууд хялбар байдлаар мэдээллээр хангах боломжийг бүрдүүлсэн байна. Банкнуудын мэдээлэл AuPer гэх мэдээллийн санд хадгалагдах бөгөөд тус сан дахь өгөгдлүүд тусгай алгоритмын дагуу “хөрвүүлэгдэж” OeNB–д хүргэгддэг байна. Одоогийн байдлаар банкны салбарын нийт санхүүгийн тайлангийн 90 гаруй хувь тус системийн дагуу боловсруулагддаг ба бүх статистик болон тогтвортой байдлын тайланг системээс гаргаж авах боломжтой байна.

Өөр нэгэн жишээ нь Руандагийн төв банк (BNR)–ны ашигладаг мэдээлэл “татах” хэлбэр байна. Сүптекийн тусламжтайгаар 600 гаруй зохицуулалттай байгууллагуудын IT системээс BNR–ны IT системд мэдээлэл автоматаар татан төвлөрдөг бөгөөд ямар төрлийн мэдээлэл гэдгээс хамаараад сар, 24 цаг, зарим тохиолдолд 15 минут тутамд (гар утсаар дамжуулсан төлбөр тооцооны мэдээлэл) татагддаг байна. Зохицуулалттай байгууллагууд мэдээллээ системд оруулахдаа ангилж өгөх ба систем тус мэдээллийн бүрэн бүтэн болон найдвартай байдлыг шалган, тодорхой

шаардлагыг хангаагүй тохиолдолд харгалзах зохицуулалттай байгууллага болон хянан шалгагчид цахим шуудан хүргүүлдэг байна. Ингэснээр BNR–д шаардлагатай мэдээллээ цаг алдалгүй авах боломж бүрджээ.

Мэдээллийн удирдлага: Сингапурын мөнгөний байгууллага (MAS) мэдээллийг цэвэрлэх болон түүний чанарыг шалгахад машин сургалтыг ашигладаг бөгөөд ингэснээр хянан шалгагчдын цагийг хэмнэж, тэдгээрийг хяналт шалгалтдаа илүү анхаарах боломжийг олгодог. Машин сургалт нь өгөгдлийн чанарыг сайжруулаад зогсохгүй алдаатай мэдээллийг холбогдох байгууллага эсвэл статистикчид анхааруулан хүргэдэг.

Виртуал тусалцаа: Филиппиний төв банк хэрэглэгчдийн өргөдөл, гомдлыг хүлээн авахдаа чатботыг ашигладаг ба энгийн асуултуудад хариулан, нэн даруй шийдвэрлэгдэх асуудлуудыг холбогдох байгууллагуудад хүргүүлдэг. Өргөдөл, гомдлын мэдээллийн сан нь хэрэглэгчдэд тулгарч буй зах зээлийн асуудлуудыг илрүүлэх боломжийг олгодог.

Зах зээлийн хяналт: Австрали, Их Британи, АНУ зэрэг улсууд дотоод мэдээлэл эзэмшигчийн, эсвэл зах зээлийг урвуулан ашиглах зэрэг сэжигтэй гүйлгээг хянахад сүптекийг ашигладаг. Жишээлбэл Английн санхүүгийн зохицуулах хороо (FCA)–ны Зах зээлийг хянах баг нь машин сургалтын тусламжтайгаар арилжаачдын хэвийн үйлдлийг ялгах боломжтой болсноор дотоод мэдээлэл эзэмшигчийг илрүүлж байна.

Зөрчлийн шинжилгээ: Хянан шалгагчдын анзаараагүй сэжигтэй гүйлгээ, холбоо зэргийг ухаалаг технологиуд илрүүлж чаддаг. Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх чиглэлээр олон улсууд сүптекийг нэвтрүүлсэн бөгөөд ингэснээр сэжигтэй гүйлгээ бүрт дүн шинжилгээ хийн мөнгө угаах магадлал бүхий сүлжээг илрүүлэх боломжтой болсон. Италийн төв банк (BoI) 5 жилийн хугацаан дахь 15 мянган еврогоос давсан бүхий л гүйлгээний мэдээллийг хэвлэл, олон нийтийн мэдээлэлтэй нэгтгэн мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Дараах хүснэгтэд улс орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллагуудын сүптекийн хэрэглээний түвшинг зориулалтаар нь харуулсан болно.

Хүснэгт. Сүптекийн хэрэглээний түвшин

Улс	Австрали	Итали	Руанда	Филиппин	Мексик	Нидерланд	Сингапур	Австри	Их британи
Зохицуулагч байгууллага	ASIC	Bol	BNR	BSP	CNBV	DNB	MAS	OeNB	SEC
Тайланг автоматжуулах									
Бодит цагийн хяналт									
Мэдээллийг нэгтгэх									
Мэдээллийг баталгаажуулах									
Мэдээллийг дүрслэх									
Виртуал туслалцаа									
Машинд “зэлтэй” зохицуулалт									
ЗЗ-ийг урвуулан ашиглах									
Дотоод мэдээлэл эзэмших									
МУТСТ									
Луйвар									
Залилан									
Зээлийн эрсдэл									
Хөрвөх чадварын эрсдэл									
Санхүүгийн эрсдэл									
Эрсдэлийг илрүүлэх									
Бодлогын үнэлгээ									
Санхүүгийн тогтвортой байдал									

Туршилтын шат

Хөгжүүлэлтийн шат

Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн

Эх сурвалж: Олон улсын төлбөр, тооцооны банк

Улс орнууд дараах гурван ерөнхий шалтгааны улмаас сүптекийг нэвтрүүлээд байна:

- Үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх;
- Зардлыг бууруулах;
- Хүчин чадлыг сайжруулах.

Олон улсын төлбөр тооцооны банкны бэлтгэсэн дээрх судалгааны тайланг дараах холбоосоор орж үзэх боломжтой.



СУДЛААЧИЙН ИНДЭР

ДАВХАР ДААТГАЛЫН ДИЗАЙНЫГ VAR-MIN, STE-MIN ЗАГВАРУУДААР ОНОВЧЛОХ

¹Доржхүү Энхтайван
Монголын актуарчдын
мэргэжлийн институт
и-мэйл: Do.Enkhtaivan@gmail.com
утас: 99050943

²Довдон Батсуурь
Хүмүүнлэгийн Ухааны
Их Сургууль
и-мэйл: Batsuuri@humanities.mn
утас: 99093904

Удиртгал—Энэ судалгааны ажлаар нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах, дисперс минимумчлах загваруудаар даатгагчийн өөрт авч үлдэх эрсдлийн дээд хязгаарыг үнэлж, оновчтой шийдийг тооцоолох практик загваруудыг танилцуулна. Сонгодог хоёр төрлийн хураамж тооцоолох аргад суурилсан оптимизацийн бодлогод даатгагч зорилтот түвшинд төлбөрийн чадвараа хангахуйц байх нэмэлт зааглалт оруулсан. Тус загварыг хоёрдугаар эрэмбийн конус программчлалын бодлогод шилжүүлж бодит хохирлын тоон мэдээнд үндэслэн R программ ашиглан эмпирик судалгааг хийж, оновчтой шийдийг тооцон бодов. Мөн энэхүү загварыг практикт хэрэглэх санал, зөвлөмжийг тусгана.

Түлхүүр үг—Дундаж хураамжийн зарчим, Стандарт хазайлтын хураамжийн зарчим, Хоёрдугаар эрэмбийн конус программчлал, Нөхцөлт сүүлний дундаж, Төлбөрийн чадвар

I. Оршил

Даатгалын компани бизнес төлөвлөгөөгөө тодорхой зорилтот түвшинд биелүүлж, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтүүдийг хангахуйцаар эрсдэлүүдийг үнэлэн урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах нь даатгалын салбарын нэн чухал асуудал юм. Даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэхтэй¹ холбоотойгоор түүнд тусгагдсан олон эрсдэлүүдээс даатгагчийн өөрт авч үлдэх гэрээний хариуцлагын дээд хэмжээг нарийвчлан судлах, математик загвараар үнэлэх шаардлагатай. Практикт даатгагчийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс хамаарч даатгалын гэрээ бүрийн хувьд ямар хэмжээний хохирлыг үүрэх боломжтойг тодорхойлох асуудал түгээмэл тулгардаг.

Даатгалын компаниуд 2019 оны байдлаар нийт 197 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, 57 тэрбум төгрөгийг гадаадын давхар даатгалд шилжүүлсэн [1] байна. Энэхүү судалгааны ажлын зорилго нь даатгагч төлбөрийн чадварыг хангахуйц байхаар өөрт авч үлдэх эрсдэлийн оновчтой шийдийн олонлогийг тооцоолж, давхар даатгалд шилжүүлэх хураамжийн хэмжээг бууруулах замаар гадагшлах валютын урсгалыг багасгах юм. Даатгагч нь давхар даатгалын программаа сайжруулах, даатгалын гэрээний нөхцөл журмыг олон улсын жишигт нийцүүлэх, хам даатгал²

¹Own risk and solvency assessment

²Co insurance

хийхийн хамт энэхүү судалгааны ажлыг зэрэгцүүлэн ашиглавал илүү үр дүнтэй.

Давхар даатгалын төлөвлөгөөний нийт эрсдэлийн дээд хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээх эрсдэлийн дээд хэмжээг³ тооцоолох, компанийн эрсдэлийн удирдлагын бодлогод энэхүү судалгааны ажлыг ашиглах бүрэн боломжтой гэж бидний зүгээс үзэж байна.

II. Судлагдсан байдал

Анх Карл Борчийн 1960 онд хийгдсэн оновчтой давхар даатгалын хэмжээг тодорхойлох судалгааны ажил маш олон актуарч болон эрдэм шинжилгээний ажилтнуудын анхаарлыг татаж эхэлсэн. Тус судалгааны үндсэн санаа нь давхар даатгалд шилжүүлэх хүлээгдэж буй эрсдэл өндөр байх тусам давхар даатгалын хураамжийн зардал өсч, үүний эсрэгээр даатгагч өөртөө өндөр хэмжээний эрсдэлийг авч үлдвэл давхар даатгалын зардал буурах бөгөөд энэхүү хоёр зөрчилдөөнт зорилгуудын улмаас оновчтой давхар даатгалын хэмжээг тодорхойлох байсан.

Гажек, Загородни, Калуска нар [2] стандарт хазайлт, дундаж-дисперсийн аргуудаар тус тус хураамжийг тодорхойлох замаар Карл Борчийн үр дүнг өргөтгөсөн.

Одоогийн байдлаар энэхүү чиглэлд олон эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгдэж, хэд хэдэн сонгодог төрлийн математик загвараар томьёолж тус асуудлыг шийдэх арга замыг тодорхойлсоны дотроос Чай, Тан нарын цуврал [2], [3], [4] ажлууд нь шинэлэг санаа, үр өгөөжтэй байдлыг агуулж байна гэж судлаачид үзжээ. Тус ажлуудын онцлог нь даатгагчийн нийт эрсдэлийг Var (value at risk), STE (conditional tail expectation) аргуудаар үнэлж, тэдгээрийг минумчлах замаар оновчтой давхар даатгалын загварыг томьёолж, дүн шинжилгээ хийсэн явдал юм. Мөн Марек Калушкагийн [10] эрдэм шинжилгээний өгүүлэлд оновчтой давхар даатгалын хэмжээг тодорхойлохдоо даатгалын компанийн ханамжийн функцийг максимумчлах байдлаар загварчилжээ.

³СЗХ-ны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн арвангурвдугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын 2.2.1

Хохирол бүрт харгалзах оновчтой давхар даатгалын хэмжээг тодорхойлох боломжтой, зааглалт нэмэхэд бодлогын шинж чанар өөрчлөгдөхгүй байх шаарлагатай байсан учраас энэхүү судалгааны аргазүйг сонгосон. Бид даатгалын компанид ноогдох хохирлын хэмжээ L тогтмолоос хэтрэхгүй байх зааглалтыг нэмж оруулсанаар практик үр дүнг илүү өгөөжтэй болсон гэж үзэж байна.

III. Судалгааны аргазүй

A. Хоёрдугаар эрэмбийн конус программчлалын бодлого

Дараах хоёрдугаар эрэмбийн конус программчлалын бодлогын ерөнхий хэлбэрийг авч үзье.

$$\begin{aligned} \min_{x \in R^n} c^T x \\ \text{s.t. } \|D_i x - d_i\| \leq p_i^T x - q_i, i = 1, 2, \dots, k, \end{aligned} \quad (1)$$

Энд $c \in R^n, D_i \in R^{(n_i-1) \times n}, d_i \in R^{n_i-1}, q_i \in R$. Мөн зааглалтын норм нь $\|u\| = (u^T u)^{\frac{1}{2}}$ байх Евклидын норм. $\|D_i x - d_i\| \leq p_i^T x - q_i$ нь n хэмжээтэй хоёрдугаар эрэмбийн конус зааглалт юм. Учир нь тус зааглалт нь доорх байдлаар тодорхойлогдсон n хэмжээтэй хоёрдугаар эрэмбийн (гүдгэр) конустай холбогддог.

$$\varepsilon_n = \left\{ \begin{pmatrix} u \\ t \end{pmatrix} : u \in R^{n-1}, t \in R, \|u\| \leq t \right\} \quad (2)$$

Дээрх ε_n олонлогийг квадрат, зайрмаг⁴ эхсүл Лоренцийн конус гэдэг. Хоёрдугаар эрэмбийн конус зааглалтын цэгүүдийн олонлог нь хоёрдугаар эрэмбийн конусын аффин буулгалтын урвуу дүр бөгөөд гүдгэр байна.

$$\|D_i x - d_i\| \leq p_i^T x - q_i \iff \begin{pmatrix} D_i \\ p_i^T \end{pmatrix} x - \begin{pmatrix} d_i \\ q_i \end{pmatrix} \in \varepsilon_{n_i}. \quad (3)$$

Тиймээс (1) бодлогын зорилгын функц гүдгэр, зааглалтын олонлог нь гүдгэр учраас гүдгэр программчлалын бодлого юм. Хоёрдугаар эрэмбийн конус программчлалын бодлого нь шугаман программчлал, гүдгэр квадрат программчлал, квадратлаг зааглалттай гүдгэр квадрат программчлал зэргийг агуулдаг. Жишээлбэл, $n_i = 1, i = 1, \dots, k$ үед шугаман программчлалын бодлого, $p_i = 0, q_i \geq 0$ үед зааглалт нь $\|D_i x - d_i\|^2 \leq q_i^2$ болж квадратлаг зааглалттай шугаман программчлалын бодлогод шилжинэ. Үүнээс гадна хоёрдугаар эрэмбийн конус программчлал нь шугаман бус гүдгэр программчлалын анги бөгөөд дотоод цэгийн арга ашиглан тооцон боддог.

B. Оновчтой давхар даатгал

Сөрөг биш, санамсаргүй хэмжигдэхүүн X -ээр даатгагчийн нийт хохирлын хэмжээг, $0 \leq f(X) \leq X$ байх $f(X)$ -ээр давхар даатгагчид ноогдох хохирлын хэмжээг тус тус тэмдэглэе. Тэгвэл давхар даатгагчийн хариуцах хэсгээс хамаарч даатгагчийн хохирлын хэмжээ $I_f(X) = X - f(X)$ болно. Давхар даатгагч авах

⁴ice cream

хураамжийн хэмжээгээ өгөгдсөн Π функцээр тооцоолдог гэж үзвэл тус хураамж нь $\Pi(f(X))$ байна. Даатгагчийн хувьд нийт хохирлын хэмжээг давхар даатгагчаас хамааралтай байдлаар $T_f := I_f(X) + \Pi(f(X))$ гэж тодорхойлж болно. Эндээс оновчтой давхар даатгалыг дараах байдлаар загварчилж болно:

$$\begin{aligned} \min_f \rho(T_f(X)) \\ \text{s.t. } \Pi(f(X)) \leq \pi \\ 0 \leq f(X) \leq X \end{aligned} \quad (4)$$

Энд ρ нь даатгагчийн нийт хохирлын функцийг эрсдэлийн хэмжээсээр үнэлэх загвар, π нь давхар даатгалд төлөх хураамжийн хэмжээ бөгөөд (4) бодлого нь даатгагчийн давхар даатгалын зардал π -ээс хэтрэхгүй, нийт хохирлын функцийг эрсдэлийн хэмжээсээр үнэлсэн үнэлгээ минимум байхаар оновчтой давхар даатгалын хэмжээ $f(X)$ -г олох юм.

Бид энэхүү судалгааны ажлаар ρ -г дисперс минимумчлах (Var-Min), нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах (STE-Min) загваруудаар, Π -г дундаж хураамжийн зарчим (??) (Expectation principle), стандарт хазайлтын хураамжийн зарчимуудаар (??) (Standard deviation principle) тус тус сонгосон. Давхар даатгалын хураамжийн зардалыг бусад хураамж тооцоолох сонгодог зарчмуудаар сольж бодлогын тавилд нийцүүлэх замаар практик үр дүнг харьцуулах боломжтой юм.

Дээрх (4) бодлогод [2] бид

$$\sum_{i=1}^N (x_i - f(x_i)) \leq L \iff \sum_{i=1}^N f(x_i) \geq \sum_{i=1}^N x_i - L \quad (5)$$

зааглалтыг нэмж өргөтгөн практик үр дүнг илүү өгөөжтэй байхаар загварчилсан. Өөрөөр хэлбэл даатгагчийн хариуцах хохирлын нийт хэмжээ тодорхой $L \in R_+$ тогтмолоос хэтрэхгүй байх нөхцөлийг нэмсэн. Эндээс бодлогын ерөнхий тавил дараах хэлбэртэй болно:

$$\begin{aligned} \min_f \rho(T_f(X)) \\ \text{s.t. } \Pi(f(X)) \leq \pi \\ 0 \leq f(X) \leq X \\ \sum_{i=1}^N f(x_i) \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (6)$$

Энд: $X^T := (x_1, x_2, \dots, x_N)$. Энэхүү зааглалтыг нэмсэнээр практик хэрэглээнд даатгалын компани L тогтмолыг нийт өр төлбөрийн дүнгээр сонгон авч төлбөрийн чадварыг зорилтот түвшинд хангахаар давхар даатгалд даатгуулах хэрэгцээгээ тодорхойлж эрсдэлээ удирдах боломжтой болно.

C. Давхар даатгалын практик загварууд

Даатгагчийн i -р хохирол x_i байх N ширхэг бодит хохирлын (нэхэмжлэл) дүнг $x^t := (x_1, x_2, \dots, x_N)$ гэж

тэмдэглэе. Энэхүү x түүвэр өгөгдлийг ашиглан ирээдүйн хохирлын хэмжээг тодорхойлох замаар оновчтой давхар даатгалын стратегийг боловсруулна. x_i хохирол бүрийн харгалзах давхар даатгалын хамгаалалт f_i -ийг $f := (f_1, f_2, \dots, f_N)$ боломжит шийдвэрийн вектор гэж үзье. Тэгвэл давхар даатгалын практик загварыг (6) бодлогоос дараах байдлаар томъёолж болно:

$$\begin{aligned} \min_f \quad & \widehat{\rho(x, f)} \\ \text{s.t.} \quad & 0 \leq f_i \leq x_i \\ & \widehat{\Pi(f)} \leq \pi \\ & \sum_{i=1}^N f_i \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (7)$$

Дээрх $\widehat{\rho(x, f)}$ ба $\widehat{\Pi(f)}$ нь харгалзан (6) бодлогын $\rho(X, f)$ ба $\Pi(f(X))$ -ийг тус тус практикт үнэлсэн үнэлгээ бөгөөд $\widehat{\rho(x, f)}$ нь x ба f -ээс, $\widehat{\Pi(f)}$ нь шийдвэрийн вектор f -ээс хамаарна. Загварын дагуу хэрэглээнд тооцоолол хийхдээ хохирлын түүхэн мэдээлэлд инфляцийн тохируулга хийж ашиглах нь илүү тохиромжтой. Энэхүү давхар даатгалын N хэмжээст оптимизацийн бодлогын оновчтой шийдийн олонлогийг $f^* := (f_1^*, \dots, f_N^*)^T$ гэж тэмдэглээд, судлагааны хэсэгт тооцооллын үр дүнг бид $(x_i, f_i^*), i = \overline{1, N}$ төгсгөлөг цэгийн олонлогийг графикаар харуулна.

Судалгааны дараах хэсэгт бид оновчтой давхар даатгалын дисперс минимумчлах болон нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах загваруудыг авч үзнэ.

D. Дисперс минимумчлах (Var-Min) загвар

Даатгагчийн нийт хохирлын функцийг эрсдэлийн хэмжээсээр үнэлэхдээ дисперсээр сонговол (6) бодлого дараах байдлаар загварчлагдана:

$$\begin{aligned} \min_f \quad & \text{Var}(I_f) = \text{Var}(X - f(X)) \\ \text{s.t.} \quad & \Pi(f(X)) \leq \pi \\ & 0 \leq f(X) \leq X \\ & \sum_{i=1}^N f(x_i) \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (8)$$

Энд дисперсийг Var -аар тэмдэглэв. Өгөгдсөн x, f -ийн хувьд $\text{Var}(X - f(X))$ зорилгын функцийг практикт дараах байдлаар үнэлэх боломжтой.

$$\begin{aligned} \widehat{\text{Var}(I_f)} &= \frac{1}{N} \sum_{i=1}^N [(x_i - f_i)^2 - (\bar{x} - \bar{f})^2] \\ &= \frac{1}{N} (x - f)^T Q (x - f) \\ &= \frac{1}{N} [f^T Q f - 2x^T Q f + x^T Q x] \end{aligned} \quad (9)$$

Энд \bar{x} ба \bar{f} нь харгалзан x түүвэр өгөгдөл болон f шийдвэрийн векторын дундаж бөгөөд Q матрицыг дараах байдлаар тодорхойлоо:

$$Q = \begin{pmatrix} q_1^T \\ \vdots \\ q_N^T \end{pmatrix} = \begin{pmatrix} 1 - \frac{1}{N} & -\frac{1}{N} & \cdots & -\frac{1}{N} \\ -\frac{1}{N} & 1 - \frac{1}{N} & \cdots & -\frac{1}{N} \\ \vdots & \vdots & \ddots & \vdots \\ -\frac{1}{N} & -\frac{1}{N} & \cdots & 1 - \frac{1}{N} \end{pmatrix}$$

Энд q_k нь k -р компонент нь $1 - \frac{1}{N}$ -тэй тэнцүү, бусад компонент нь $-\frac{1}{N}$ тэнцүү байх N хэмжээст багана вектор.

Мөн $0 \leq f(x) \leq x$ зааглалт нь тухайн тохиолдолд $0 \leq f_i \leq x_i, i = \overline{1, N}$ байх бөгөөд $\Pi(f) \leq \pi$ нөхцөлийг хангах давхар даатгалын хураамжийн зааглалтыг практикт үнэлсэн үнэлгээ $\widehat{\Pi(f)} \leq \pi$ байна. Эндээс дисперс минимумчлах давхар даатгалын практик загварыг дараах байдлаар томъёолж болно:

$$\begin{aligned} \min_{f \in \mathbb{R}^N} \quad & f^T Q f - 2x^T Q f \\ \text{s.t.} \quad & 0 \leq f_i \leq x_i, i = \overline{1, N} \\ & \widehat{\Pi(f)} \leq \pi \\ & \sum_{i=1}^N f_i \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (10)$$

E. Дундаж хураамжийн зарчим

Давхар даатгалын хураамжийн зардалыг $\Pi(Z) = (1 + \theta)E(Z)$ байх дундаж хураамжийн зарчмаар тооцоолдог гэж үзье.

$$\widehat{\Pi(f)} \leq \pi \Leftrightarrow (1 + \theta)\bar{f} \leq \pi \Leftrightarrow e^T f \leq \frac{(1 + \theta)}{N} \pi$$

Тэгвэл $\theta \geq 0$ байх энэхүү шугаман зааглалтаас дисперс минимумчлах практик загвар нь гүдгэр квадратлаг програмчлалын хоёрдугаар эрэмбийн конус програмчлал (SOCP⁵) бодлогод шилжих бөгөөд тус зааглалтыг $(1 + \theta)\bar{f} = \pi$ байх тэнцэтгэл зааглалтаар сольвол бодлого дараах байдлаар томъёологдоно:

$$\begin{aligned} \min_{f \in \mathbb{R}^N} \quad & f^T Q f - 2x^T Q f \\ \text{s.t.} \quad & 0 \leq f_i \leq x_i, i = \overline{1, N} \\ & (1 + \theta) \frac{1}{N} e^T f = \pi \\ & \sum_{i=1}^N f_i \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (11)$$

Энд e нь бүх компонент нь нэгтэй тэнцүү N хэмжээст багана вектор, θ нь давхар даатгагчийн харьцангуй ачааллын коэффициент.

⁵Second-order conic programming

Ү. Стандарт хазайлтын хураамжийн зарчим

Давхар даатгалын хураамжийн зардалыг $\Pi(Z) = E(Z) + \beta\sqrt{Var(Z)}$ байх стандарт хазайлтын хураамжийн зарчмаар тооцоолдог гэж үзье.

$$\widehat{\Pi}(f) \leq \pi \Leftrightarrow \bar{f} + \beta \frac{\|Qf\|}{\sqrt{N}} \leq \pi \Leftrightarrow \|Qf\| \leq -\frac{1}{\beta\sqrt{N}}e^T f + \frac{\sqrt{N}}{\beta}\pi$$

Тэгвэл $\beta \geq 0$ байх дисперс минимумчлах практик загвар нь гүдгэр квадратлаг программчлалын хоёрдугаар эрэмбийн конус программчлал бодлогод мөн шилжих бөгөөд бодлого дараах байдлаар томьёологдоно:

$$\begin{aligned} \min_{f \in \mathbb{R}^N} & f^T Qf - 2x^T Qf \\ \text{s.t.} & 0 \leq f_i \leq x_i, i = \overline{1, N} \\ & \|Qf\|_2 \leq -\frac{1}{\beta\sqrt{N}}e^T f + \frac{\sqrt{N}}{\beta}\pi \\ & \sum_{i=1}^N f_i \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (12)$$

Энд $\|\cdot\|_2$ нь $\|u\|_2 = (u^T u)^{\frac{1}{2}}$ байх Евклидын норм, β нь давхар даатгагчийн харьцангуй ачааллын коэффициент.

Г. Нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах (СТЕ-Min) загвар

Тодорхойлолт 1: $1 - \alpha$, ($0 < \alpha < 1$), итгэх түвшинд хохирлын Z санамсаргүй хэмжигдэхүүний Var ⁶:

$$VaR_\alpha(Z) = \inf\{z \in \mathbb{R} : Pr(Z \leq z) \geq 1 - \alpha\}$$

Тодорхойлолт 2: $1 - \alpha$, ($0 < \alpha < 1$), итгэх түвшинд хохирлын Z санамсаргүй хэмжигдэхүүний CTE ⁷:

$$CTE_\alpha(Z) = \frac{1}{\alpha} \int_0^\alpha VaR_q(Z) dq$$

Эрсдэлийн хэмжээсийг СТЕ загвараар үнэлвэл (6) бодлого нь дараах бодлого руу шилжинэ:

$$\begin{aligned} \min_f & CTE_\alpha(T_f) = CTE_\alpha(X - f(X) + \Pi(f(X))) \\ \text{s.t.} & \Pi(f(X)) \leq \pi \\ & 0 \leq f(X) \leq X \\ & \sum_{i=1}^N f(x_i) \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (13)$$

⁶Value at risk

⁷Conditional tail expectation

(13) бодлогын f^* шийдийг олох нь (14) бодлогын (ξ^*, f^*) шийдүүдийг олохтой тэнцүү чанартай учраас дээрх 2 бодлого нь эквивалент юм.

$$\begin{aligned} \min_{(\xi, f)} & G_\alpha(\xi, f) := \xi + \frac{1}{\alpha} E[(X - f(X) + \Pi(f(X)) - \xi)_+] \\ \text{s.t.} & \Pi(f(X)) \leq \pi \\ & 0 \leq f(X) \leq X \\ & \sum_{i=1}^N f(x_i) \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (14)$$

Математик дунджийг түүврийн дундажаар солих замаар нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах бодлого нь давхар даатгалын практик загварт дараах хэлбэртэй тавигдана:

$$\begin{aligned} \min_{(\xi, f)} & G_\alpha(\widehat{\xi}, \widehat{f}) = \xi + \frac{1}{\alpha N} \sum_{i=1}^N [(x_i - f_i + \widehat{\Pi}(f)) - \xi]_+ \\ \text{s.t.} & \widehat{\Pi}(f) \leq \pi \\ & 0 \leq f_i \leq x_i, i = \overline{1, N} \\ & \sum_{i=1}^N f_i \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (15)$$

Нэмэлт шийдвэрийн вектор $z = (z_1, \dots, z_N)^T$ хувьсагчийг оруулж ирсэнээр (15) бодлогын хувьд (ξ^*, f^*) олох ба (16) бодлогын хувьд (ξ^*, f^*, z^*) тооцоолох нь адил учраас энэхүү 2 бодлого нь эквивалент юм.

$$\begin{aligned} \min_{(\xi, f, z)} & \xi + \frac{1}{\alpha N} \sum_{i=1}^N z_i \\ \text{s.t.} & \widehat{\Pi}(f) \leq \pi \\ & 0 \leq f_i \leq x_i, i = \overline{1, N} \\ & z_i \geq 0, z_i \geq x_i - f_i + \widehat{\Pi}(f) - \xi, i = \overline{1, N} \\ & \sum_{i=1}^N f_i \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (16)$$

Өмнө томьёолсноор (16)-ийг дундаж хураамжийн зарчмаар практик хэрэглээнд загварчилвал бодлого дараах хэлбэртэй болно:

$$\begin{aligned} \min_{(\xi, f, z)} & \xi + \frac{1}{\alpha N} \sum_{i=1}^N z_i \\ \text{s.t.} & 0 \leq f_i \leq x_i, i = \overline{1, N} \\ & z_i \geq 0, i = \overline{1, N} \\ & z_i \geq x_i - f_i + (1 + \theta)\bar{f} - \xi \\ & \bar{f} \leq \frac{\pi}{1 + \theta} \\ & \sum_{i=1}^N f_i \geq \sum_{i=1}^N x_i - L \end{aligned} \quad (17)$$

Мөн (16)-ийг стандарт хазайлтын хураамжийн зарчмаар практикт загварчилвал бодлого дараах

хэлбэртэй тавигдана:

$$\begin{aligned}
 \min_{(\xi, f, z)} \quad & \xi + \frac{1}{\alpha N} \sum_{i=1}^N z_i \\
 \text{s.t.} \quad & 0 \leq f_i \leq x_i, z_i \geq 0, i = \overline{1, N} \\
 & \|Qf\|_2 \leq -\frac{1}{\beta\sqrt{N}} e^T f + \frac{\sqrt{N}}{\beta} \pi \\
 & \|Qf\|_2 \leq -\frac{1}{\beta\sqrt{N}} e^T f + \\
 & + \frac{\sqrt{N}}{\beta} (f_i + \xi + z_i - x_i), i = \overline{1, N} \\
 & \sum_{i=1}^N f_i \geq \sum_{i=1}^N x_i - L
 \end{aligned} \quad (18)$$

Судалгааны ажлын давхар даатгалын дизайныг оновчлох бодлогыг хоёрдугаар эрэмбийн конус программчлалын эквивалент дэд бодлого руу шилжүүлэн R программчлалын CVXR багцын тусламжтайгаар бодно.

IV. Судалгааны хэсэг

Миг даатгал компанийн 2018 оны нэг жилийн бодит нэхэмжлэлийн мэдээллийг ашиглан даатгагчийн өөрт авч үлдэх эрсдэлийн дээд хязгаарыг трити гэрээний хувьд дисперс минимумчлах, нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах практик загваруудаар үнэллээ. Давхар даатгалын хураамжийн зардалыг дундаж хураамжийн зарчим, стандарт хазайлтын хураамжийн зарчмын дагуу тооцоолох тохиолдлуудад загвар тус бүрийн хувьд үнэлгээг хийлээ. Өөрөөр хэлбэл (11),(12),(17),(18) загваруудаар тодорхойлогдсон оптимизацийн бодлогуудыг бодож, үр дүнд шинжилгээ хийсэн.

A. Өгөгдлийн боловсруулалт

Даатгалын нэхэмжлэлийн (8156×4) хэмжээс бүхий түүхий өгөгдөлд дараах үе шаттайгаар боловсруулат хийлээ.


- Иргэдийн даатгалын бүтээгдэхүүний гэрээтэй холбогдох нэхэмжлэлийн мэдээг хассан. Учир нь онцлох цөөн хэдэн төрлийн гэрээс бусад тохиолдолд иргэдийн зах зээл дахь даатгалын эрсдэлийг хураамжийн хэмжээгээр бүрэн удирдах боломжтой юм. Хохирлын давтамж нэмэгдэж мөнгөн урсгалын хувьд нөхөн төлбөрийн нөөц сан нэмэгдсэн тохиолдолд хохирлын харьцааг тодорхой түвшинд бууруулж, зардалаа танаа замаар активын хэмжээг⁸ нэмэгдүүлж төлбөрийн чадварын эрсдэлээ удирдаж чадна гэж үзлээ.
- Бидний гол анхаарч үзэх ёстой өгөгдөл нь өндөр үнэлгээ бүхий гэрээнээс нэг удаагийн даатгалын тохиолдлоор их хэмжээний нөхөн төлбөр олгож болзошгүй, даатгагчийн төлбөрийн чадварт

гэнэтийн сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл дагуулсан нэхэмжлэлүүд юм. Иймд 20 хүртэл сая төгрөгийн давтамжтай нэхэмжлэлийг даатгагчийн актив боломжтой гэж үзээд харгалзах мэдээллийг хасав.

B. Судалгааны үр дүн

Дистперс минимумчлах загварын дагуу, дундаж хураамжийн зарчмаар $\theta = 0.3, L = 800$ сая төгрөг үед $\pi = 15, 25, 40, 50$ сая төгрөг байх тохиолдлуудад тооцоолсон үр дүнг Зураг 3.3-т харууллаа. Оновчтой шийдүүдийг $\{(x_i, f_i^*), i = \overline{1, N}\}$ байдлаар дүрслэв. Зураг 3.3-

Зураг 1. Var-Min зорилгын функцтэй, дундаж хураамжийн зарчим бүхий зааглалттай загварын эмпирик үр дүн, сая.төг




т дүрсэлсэнээр давхар даатгалын хураамжийн зардал 15 сая төгрөг байх тохиолдолд ойролцоогоор 100 сая төгрөг хүртэлх хохирлыг даатгалын компани өөрөө хариуцаж түүнээс давсан хэсгийг давхар даатгалд даатгуулах шаардлагатай гэсэн үр дүн гарсан бол $\pi = 25$ сая төгрөг байх үед 50 сая төгрөгөөс дээш хохирлуудын тодорхой хэсгүүдийг давхар даатгалд шилжүүлэх нь зүйтэй гэсэн оновчтой хариу өгч байна. Харин давхар даатгалын хураамжийн зардал 40 ба 50 сая төгрөг байх үед даатгалын компани 10 сая төгрөгөөс дээш бүх хохирлын ихэнх хэсгийг шилжүүлэх боломжтой байна.

Дисперс минимумчлах загварын дагуу, стандарт хазайлтын хураамжийн зарчмаар $\theta = 0.3, L = 800$ сая төгрөг үед $\pi = 15, 25, 40, 50$ сая төгрөг байх тохиолдлуудад тооцоолсон үр дүнг Зураг 3.4-т харууллаа. Оновчтой шийдүүдийг $\{(x_i, f_i^*), i = \overline{1, N}\}$ байдлаар дүрслэв. Зураг 3.4-т дүрсэлсэнээр давхар даатгалын хураамжийн зардал 15 сая төгрөг байх тохиолдолд хохирол бүрийн бага хэсгийг жигд байдлаар давхар даатгалд даатгуулах шаардлагатай гэсэн үр дүн гарсан бол $\pi = 25, 50$ сая төгрөг байх тохиолдлуудад харгалзан 60 ба 25 сая төгрөгөөс дээш хохирлуудын тодорхой хэсгүүдийг давхар даатгалд шилжүүлэх нь зүйтэй гэсэн оновчтой хариу өгч байна. Харин давхар даатгалын хураамжийн зардал 50 сая төгрөг байх үед даатгалын компани 10 сая төгрөгөөс дээш бүх хохирлын ихэнх хэсгийг шилжүүлэх боломжтой байна.


Нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах загварын дагуу, дундаж хураамжийн зарчмаар $\theta = 0.3, L = 800$

⁸Зөвшөөрөгдөх хөрөнгийн хэмжээ

Зураг 2. Var-Min зорилгын функцтэй, стандарт хазайлтын хураамжийн зарчим бүхий зааглалттай загварын эмпирик үр дүн, сая.төг



Зураг 3. CTE-Min зорилгын функцтэй, дундаж хураамжийн зарчим бүхий зааглалттай загварын эмпирик үр дүн, сая.төг




сая төгрөг үед $\pi = 15, 25, 40, 50$ сая төгрөг байх тохиолдолуудад тооцоолсон үр дүнг Зураг-3.5-т харууллаа. Оновчтой шийдүүдийг $\{(x_i, f_i^*), i = \overline{1, N}\}$ байдлаар дүрслэв. Зураг 3.5-т дүрсэлсэнээр давхар даатгалын хураамжийн зардал 15 сая төгрөг байх тохиолдолд ойролцоогоор 100 сая төгрөг хүртэлх хохирлыг даатгалын компани өөрөө хариуцаж, $\pi = 25$ үед 55 сая төгрөгөөс дээш хохирлуудын тодорхой хэсгүүдийг давхар даатгалд шилжүүлэх шаардлагатай гэсэн үр дүн гарсан.

Харин давхар даатгалын хураамжийн зардал 40 ба 50 сая төгрөг байх үед даатгалын компани ойролцоогоор 10 сая төгрөгөөс дээш бүх хохирлын ихэнх хэсгийг шилжүүлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл Var-Min зорилгын функцтэй, дундаж хураамжийн зарчмаар илэрхийлэгдэх зааглалттай загвартай ойролцоо үр дүн гарсан.

Нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах загварын дагуу, стандарт хазайлтын хураамжийн зарчмаар $\theta = 0.3, L = 800$ сая төгрөг үед $p_i = 15, 25, 40, 50$ сая төгрөг байх тохиолдолуудад тооцоолсон үр дүнг Зураг 3.6-т харууллаа. Оновчтой шийдүүдийг $\{(x_i, f_i^*), i = \overline{1, N}\}$ байдлаар дүрслэв. Зураг 3.6-д дүрсэлсэнээр давхар даатгалын хураамжийн зардал 15 сая төгрөг байх тохиолдолд ойролцоогоор 40 сая төгрөг хүртэлх хохир-

Зураг 4. CTE-Min зорилгын функцтэй, стандарт хазайлтын хураамжийн зарчим бүхий зааглалттай загварын эмпирик үр дүн, сая.төг



лыг давхар даатгалд шилжүүлж, 70 сая төгрөг хүртэлх хохирлын 35 сая төгрөгийг давхар даатгалд хамруулж, 70 сая төгрөгөөс дээш хохирол бүрийн тодорхой хэсгийг давхар даатгалд даатгуулах нь оновчтой гэсэн үр дүн гарлаа. Давхар даатгалын хураамжийн зардал 25, 40, 50 сая төгрөг байх үед даатгалын компани ойролцоогоор 10 сая төгрөгөөс дээш бүх хохирлын ихэнх хэсгийг шилжүүлэх боломжтой байна. Энэхүү эмпирик судалгаагаар CTE-Min загварын стандарт хазайлтын хураамжийн зарчмаар илэрхийлэгдэх зааглалттай тохиолдолд давхар даатгалын компани бусад загваруудтай харьцуулахад хамгийн бага үнийн санал ирүүлэх магадлалтай байна. Давхар даатгалын хураамжийн

Хүснэгт I
Загваруудын үр дүн, сая.төг

Дисперс минимумчлах загвар					
EP зарчим			StdP зарчим		
π	$(x - f^*)$	$\max(f^*)$	π	$(x - f^*)$	$\max(f^*)$
15	39.53	126.22	15	40	51
25	31.84	172.05	25	37.15	132.88
40	20.29	202.49	40	26.94	187.36
50	13.65	209.19	50	18.5	204.37

Нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах загвар					
EP зарчим			StdP зарчим		
π	$(x - f^*)$	$\max(f^*)$	π	$(x - f^*)$	$\max(f^*)$
15	39.53	126.22	15	8.97	180.96
25	31.84	172.05	25	8.26	222.87
40	21.63	200.99	40	0	222.87
50	21.63	200.99	50	0	222.87

зардал өсөхөд загвар тус бүрийн хувьд тооцоолсон оновчтой шийдүүдээс хамаарч даатгагчийн хариуцах дундаж нөхөн төлбөр буурч, давхар даатгагчийн хариуцах хамгийн их хохирлын хэмжээ өсч байна. Өөрөөр хэлбэл даатгалын компани бизнес төлөвлөгөөнд тусгасан давхар даатгалын хураамжийн зардал ба өр төлбөр зорилтот түвшинөөс хэтрэхгүй байхаар даатгалын эрсдэлийг удирдах боломжтойг харууллаа.

V. Дүгнэлт

Оновчтой давхар даатгалыг тодорхойлоход хохирлын тархалт, түүний сүүлийг онцлон судлах зайлшгүй шаардлагатай байдаг. Практикт хохирлын тархалтын функц ихэвчлэн урт сүүлтэй байдаг бөгөөд энэ чиглэлд судалгаа хийдэг бусад судлаачдын эрдэм шинжилгээний өгүүлүүдэд дурьдсанаар нөхцөлт сүүлний дунджийг минимумчлах загвар энэ тохиолдолд сайн үр дүнтэй байсаныг онцлох нь зүйтэй юм. Тухайлбал илтгэгч тархалт, паретогийн тархалттай үед нарийвчилсан судалгааг хийжээ.

Эмпирик судалгааны ажлаар цөөн тооны өгөгдөл ашиглан тооцоолол хийхэд давхар даатгалын хураамжийн хэмжээ өөрчлөгдөх бүрт загварууд ялгаатай, оновчтой шийдүүд өгч байгаа нь загваруудыг бага хэмжээний хохирлын мэдээлэлд ч ашиглах боломжтойг харуулж байна.

Давхар даатгалыг оновчлох конус программчлалын энэхүү арга нь давхар даатгалын хохирлын функцийг даатгагчийн өөрт авч үлдэх эрсдэлийн дээд хязгаараас хамааруулан тодорхойлж байгаа тул давхар даатгалын аль ч төрлийн хэлцэл хийхэд ашиглаж болно. Мөн давхар даатгагчийн ирүүлсэн үнийн саналыг бодитой эсэхэд шинжилгээ хийх боломж бүрдэхээс гадна нэмэлт зааглалт (5) оруулснаар төлбөрийн чадварыг зорилтот түвшинд хангахаар нийт гэрээгээр хүлээх эрсдэлийн хэмжээг тодорхойлж болно.

Практикт хохирлын бодит өгөгдлийг нэхэмжилсэн дүнгээр сонгож, инфляцийн тохируулга хийвэл тохиромжтой. Жишээлбэл, мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг⁹ нэхэмжилсэн хохирлын дүнгээр байгуулж, тус нөөц сан нь даатгалын компанийн өр төлбөрөөр бүртгэгдэн төлбөрийн чадварт шууд нөлөө үзүүлнэ. θ -г давхар даатгагчийн хохирлын харьцааг эсхүл хохирол нөхөлтийн харьцааг тооцож сонгох шаардлагатай.

L -г тодорхойлохдоо ямар хэмжээний өр төлбөрийг тухайн даатгалын компани санхүүгийн чадавхийн хувьд даах боломжтойг судалж, дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Хэрэв бүтээгдэхүүн бүрийн хувьд L -г олох боломжгүй бол нөхөн төлбөрийн эзлэх хувийн жинг ашиглан тооцсоны дараа учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг нэмэх нь зүйтэй. Энэхүү параметруудээс гадна давхар даатгалын ямар хэлцлийн хувьд тооцоолол хийхээс шалтгаалж даатгалын бүтээгдэхүүн эсхүл хэлбэрээр хохирлыг ангилж өгөгдлийн боловсруулалт хийх нь чухал гэж үзлээ.

Цаашид бусад хураамж бодох сонгодог аргуудын тусламжтай загварчлах, практикт үр өгөөжтэй зааглалтуудаар өргөтгөх, даатгалын үнэлгээг загварт нэмж оруулах, тухайн загварт тохирох оптимизацийн аргуудыг судлах хэрэгтэй.

⁹СЗХ-ны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”ийн гуравдугаар хэсрэлт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 2.3

Ашигласан ном

- [1] СЗХ, "Даатгалын салбарын 2019 оны IV улирлын санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан", 2020.
- [2] Ken Seng Tan, Chengguo Weng, "Empirical Approach for Optimal Reinsurance Design", North American Actuarial Journal, pp. 315-342, 2014.
- [3] Jun Cai, Ken Seng Tan, "Optimal Retention for a Stop-Loss Reinsurance", 2009.
- [4] Ken Seng Tan, Chengguo Weng, Yi Zhang, "VAR and CTE Criteria for Optimal Quota-Share and", North American Actuarial Journal, pp. 459-482, 2012.
- [5] Michael Grant, Stephen Boyd, Yinyu Ye, "Disciplined Convex Optimization", Global optimization: from theory to implementation, pp. 155-210, 2006.
- [6] Anqi Fu, Balasubramanian Narasimhan, Stephen Boyd, "CVXR: An R Package for Disciplined Convex Optimization", arXiv: 1711.07582, 2017.
- [7] Rob Kaas, Marc Goovaerts, Jan Dhaene, Michel Denuit, "Modern Actuarial Risk Theory: Using R", Heidelberg: Springer-Verlag Berlin Heidelberg, 2009.
- [8] Miguel Sousa Lobo, Lieven Vandenberghe, Stephen Boyd, Herve Lebert, "Applications of second-order cone programming", Linear Algebra and its Applications 284, pp. 193-228, 1998.
- [9] Bowers, N.J., Gerber, H.U., Hickman, J.C., Jones, D.A. and Nesbitt, C.J, "Actuarial Mathematics", Schaumburg: The Society of Actuaries, 1997.
- [10] Marek Kaluszka "Optimal reinsurance under mean-variance premium principles", Insurance: Mathematics and Economics 28, pp. 61-67, 2001.
- [11] Р.Энхбат "Оптимизаци 5", Улаанбаатар хот, 2018.
- [12] David C.M.Dickson "Insurance risk and ruin", Cambridge University Press, 2005.

ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улсад хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өмч хувьчлалын ажлыг хэрэгжүүлэх зорилгоор БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд 1992–1995 оны хооронд 475 улсын үйлдвэрийн газрын хувьцааг цэнхэр, ягаан тасалбараар 1.2 сая иргэнд эзэмшүүлж хувьчилснаар Монгол Улсад орчин үеийн зах зээлийн эдийн засгийн үндэс суурь тавигдаж байсан билээ. МХБ нь энэхүү түүхэн үүргээ амжилттай гүйцэтгэхийн сацуу Монгол улсад хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэн, төгөлдөржүүлэх зорилгоор 1996 оноос Засгийн газрын бондын арилжаа, 2001 оноос компанийн бондын арилжаа, 2005 онд анхны IPO буюу “Монгол Шилтгээн” ХК-ийн хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалах үйл ажиллагааг тус тус амжилттай зохион байгуулж байсан.

МХБ нь дотоодын зах зээлийг олон улсын стандартад нийцүүлэх зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу олон улсад нэр хүнд бүхий Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратегийн түвшинд хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалт, техник, технологи, дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлсэн билээ. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 онд шинэчлэн найруулахад МХБ-ийн зүгээс чухал үүрэгтэйгээр оролцож, үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилсний үр дүнд гадаад улсын компанийн үнэт цаасны давхар бүртгэл, хадгаламжийн бичиг, төлбөр тооцооны дараа төлбөрт систем, үнэт цаасны номинал болон бенефициар өмчлөл, кастодианы үйлчилгээ зэрэг олон шинэ концептууд зах зээлд шинээр нэвтэрсэн юм. Ингэснээр 2018 онд гадаад улсын компанийн үнэт цаасыг анх удаа МХБ дээр давхар бүртгэж арилжаалсан, арилжааны үнийн дүн хамгийн дээд хэмжээндээ хүрсэн, 2019 онд анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн дээд амжилтаа тогтоосон зэргээр хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд урьд өмнө байгаагүйгээр идэвхжиж, чамлахааргүй их амжилтанд хүрч байна. Монголын хөрөнгийн бирж нь 2020 оны эхний байдлаар 40 гаруй аж ахуйн нэгжид 187.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэхэд зуучлан, нийт 3.3 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа зохион байгуулаад байна.

Эрхэм зорилго:

Санхүүгийн зах зээлд дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгөөр урт хугацаанд зуучлан хүргэх үүрэгтэй үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулна.

Үйл ажиллагаа:

Монголын хөрөнгийн бирж нь өнөөдрийн байдлаар 199 бүртгэлтэй компани болон 54 үнэт цаасны компаниудын гишүүнчлэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. 2020 оны эхний байдлаар 40 гаруй аж ахуйн нэгжид 187.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэхэд зуучлан, нийт 3.3 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа зохион байгуулаад байна.

Хамтын ажиллагаа:

Монголын хөрөнгийн бирж нь олон улсын жишгийн дагуу үйл ажиллагаагаа явуулах, зах зээлийг дэмжсэн эрх зүйн орчныг бий болгох, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлд Санхүүгийн зохицуулах хороотой нягт хамтран ажиллаж ирсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлж байгаа оновчтой бодлого, шуурхай арга хэмжээний үр дүнд зах зээлд сүүлийн үед зах зээлд томоохон ахиц дэвшил гарч, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах зохицуулалтыг цоо шинээр бүрдүүлж, хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг сайжруулж хариуцлагажуулах, төлбөр тооцооны дараа төлбөрт Т+2 горимд нэвтрүүлэх ажлуудыг хамтран үр дүнтэй хэрэгжүүлээд байна.

Бодлогын арга хэмжээ:

1. Хөрөнгийн зах зээлд олон улсын төлбөр тооцооны дараа төлбөрт Т+2 стандартыг 2020 оны 03 дугаар сард нэвтрүүлсэн.

Үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог олон улсад Т+2/3 зарчмаар гүйцэтгэдэг бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчид, тэр дундаа институционал хөрөнгө оруулагчид нь зөвхөн энэхүү олон улсын жишигт нийцсэн зах зээлд хөрөнгө оруулдаг билээ. Уг стандартыг нэвтрүүлэх зорилгоор хөрөнгийн зах зээлийн оролцогчид 2017 оноос хойш ажилласан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны бодлогын дэмжлэгээр уг стандартыг 2020 оны 03 дугаар сард нэвтрүүлсэн нь зах зээлийг олон улсын жишигт хүргэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын аль алинд нь арилжааны таатай орчинг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, улмаар FTSE Russell компанийн Фронттиер зах зээлийн ангиллын шалгуурыг хангах зэрэг олон талын ач холбогдолтой арга хэмжээ болсон билээ.

2. Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох

Хөрөнгийн зах зээлд урт хугацааны хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох, шинээр гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулах эрэлт тасралтгүй бий болгох, хувьцааны ханш тогтвортой байх, түүнчлэн компаниудын үнэт цаас гаргах сонирхлыг нэмэгдүүлэхэд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо шийдвэрлэх ач холбогдолтой байдаг. Иймд дотоодын хөрөнгө оруулалтын сангуудыг идэвхжүүлэх чиглэлд хамгийн анхны хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 оны 06 дугаар сард олгосон нь олон нийтийн хөрөнгийг мэргэжлийн удирдлагаар хангаж зах зээлд анхны олон нийтийн хөрөнгө оруулалтын санг бий болгох эхний алхмыг амжилттай тавиад байна.

3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх

Манай хөрөнгийн зах зээл нь хувьцаа, бонд гэсэн үндсэн хоёр бүтээгдэхүүнтэй байгааг цаашид төрөлжүүлэх нэмэгдүүлэхийн тулд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх эрх зүй, зохицуулалтын орчинг зайлшгүй бий болгох шаардлагатай билээ. Үүний тулд МХБ нь олон нийтэд нээлттэй арилжаалдаг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээ, давхар бүртгэлтэй үнэт цаасыг хил дамнуулан хөрвүүлэх үйлчилгээ, биржийн бус зах зээлийн арилжаа /OTC зах зээл/ зэргийг нэвтрүүлэхээр Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж байна.

Зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх, санхүүгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэхэд зохицуулагч байгууллага болон бусад зах зээлийн оролцогчдын харилцан ойлголцол, нягт хамтын ажиллагаа шийдвэрлэх нөлөөтэй байдаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн хөгжлийг ойлгож, дэмжиж ажиллаж байгаад бусад зах зээлийн оролцогчдын өмнөөс талархал илэрхийлье.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

1 Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн санаачилгын зөвлөлийн 5 дугаар уулзалт боллоо

Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (СХН, Alliance for Financial Inclusion, AFI)–ийн Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн санаачилгын зөвлөлийн 5 дугаар уулзалт цахим хэлбэрээр 2020 оны 6 дугаар сарын 1,2,3–ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус цахим уулзалтын зорилго нь 2019–2020 онд Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт, тулгарч буй саад бэрхшээл болон улс орон бүрийн авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хийсэн ажлын үр дүнг бусад орны гишүүдэд танилцуулах, түүнчлэн 2020–2021 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, “Цахим аюулгүй байдлын хөгжиж буй орчин”–ы талаар ярилцлаа.



2 “Өсвөр насны хүүхдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд тулгарч буй сорилт, тэдний хандлага” сэдэвт хэлэлцүүлэг боллоо

Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Насан туршийн боловсролын үндэсний төв, Монголын банкны холбоо, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбортой хамтран “Өсвөр насны хүүхдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд тулгарч буй сорилт, тэдний хандлага” сэдэвт онлайн семинар, хэлэлцүүлэгийг зохион байгууллаа.

“САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ОНЛАЙН СЕМИНАР, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Банкны ажилтны өдрийг тохиолдуулан Банк Санхүүгийн Академи нийтийн харилцааны хүрээнд жил бүр тодорхой сэдвийн дор, зорилтот бүлэгт нэгдсэн Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх семинар, холбогдох үйл ажиллагааг зохион явуулдаг.

Семинарын зорилго нь олон нийтийн санхүүгийн сурь, мэдлэгийг дээшлүүлэх хөгшлөв, зорилтын хүрээнд нийтийн идэвхийг өрнүүлэхэд түүчээлэн оролцож, талуудын үйл ажиллагаа, потенциалыг таниулах нэгдмэл талбартаар дамжуулан туршлага хуваалцах, мэдлэгээ солилцох, түүхээд оршино.

Семинарын сэдэв: “Өсвөр насны хүүхдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд тулгарч буй сорилт, тэдний хандлага”


3. Гаалийн удирдах ажилтнуудад сургалт хийлээ

Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр болон Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Гаалийн ерөнхий газрын удирдах ажилтнууддаа зориулж Урт хугацааны даатгагчдаас төрийн албан хаагчдыг цогц даатгалд хамруулах даатгалын бүтээгдэхүүний сургалт, танилцуулах ажлыг “Нэйшл лайф” ХХК–тай хамтран 2020 оны 6 дугаар 17–ны өдөр зохион байгууллаа.




4. Даатгалын хохирол үнэлэгчийн эрх олгох сургалтыг цахимаар зохион байгууллаа

Санхүүгийн зохицуулах хороо Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоотой хамтран 2020 оны 6 дугаар сарын 8–10–ны өдрүүдэд Даатгалын хохирол үнэлэгчийн эрх олгох сургалтыг цахимаар зохион байгууллаа. Тус сургалтад нийслэл болон 9 аймгийн Даатгалын хохирол үнэлгээний 12 компаниас 36 иргэн хамрагдаж шалгалт өгөв.



5. Иргэдийн санхүүгийн боловсролд зориулж подкастыг түгээж байна

Санхүүгийн зохицуулах хорооноос олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Даатгалын ерөнхий ангилал, даатгалын нөхөн төлбөр, IPO, ББСБ–ын үндсэн үйл ажиллагаа, Зээл, Компанийн бонд, Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа, Хөрөнгийн зах зээл, Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, Хөрөнгө оруулалтын сан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг сэдвээр подкастыг бэлтгэн түгээж байна.



ХЭРЭГЛЭГЧ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг

хэрэгжүүлдэг. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 137 өргөдөл, гомдол ирсэн байна.

Хүснэгт. Нийт өргөдлийн тоо /улирлаар/

№	Салбар	2017.1	2017.2	2017.3	2017.4	2018.1	2018.2	2018.3	2018.4	2019.1	2020.1
1	Даатгал	42	23	29	45	40	38	25	47	43	90
2	Үнэт цаас	23	12	12	20	28	29	21	30	17	26
3	ББСБ	13	9	7	13	20	11	11	14	20	20
4	ХЗХ	8	5	1	5	4	2	30	17	2	1
	Нийт	86	49	49	83	92	80	87	108	82	137

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээл, хадгаламж зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо буурсан бол даатгалын салбартай холбоотой өргөдлийн тоо өсөж, ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1–д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл

дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Санхүүгийн зохицуулах хороонд хандаж, 2020 оны 1 дүгээр улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд нийт 137 өргөдөл, гомдол ирснээс: Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

Хүснэгт. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тоо

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Өргөдлийн тоо
Шийдвэрлэж, хариуг өгөв. Үүнээс:	
Хугацаанд нь шийдвэрлэсэн	121
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-
Шийдвэрлэх шатандаа байгаа. Үүнээс:	
Хуулийн хугацаанд хянагдаж буй	10
Хугацааг нь сунган хянагдаж буй	6

Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

Хүснэгт. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа /хоногоор/



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ОЛОН УЛСЫН ХАНДЛАГА

Компанийн засаглалын дэлхий нийтийн 2020 оны хандлагыг тодорхойлохын тулд Russell Reynolds холбооноос 40 гаруй мэргэжлийн ба идэвхтэй хөрөнгө оруулагчид, тэтгэврийн сангийн менежерүүд, итгэмжлэгдсэн зөвлөхүүд болон компанийн засаглалын мэргэжилтнүүдтэй хэлэлцүүлэг зохион байгуулжээ. Энэхүү хэлэлцүүлэг, судалгааны үр дүнгээс дор дурдсан 5 асуудал энэ жилийн хандлагыг тодорхойлохоор байна. Үүнд:

1

Байгаль орчин болон нийгмийн асуудал

2

Компанийн зорилго, зорилтын ач холбогдол

3

Байгууллагын соёл, хүмүүн капиталын менежмент

4

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн

5

Компаниуд илүү өргөн хүрээний идэвхтэй байдалтай тулгарна

1. Байгаль орчин болон нийгмийн асуудал: Өмнө нь бид сайн засаглалыг бий болгоход онцгой ач холбогдол өгдөг байсан бол одоо хөрөнгө оруулагчдын хувьд байгаль орчин болон нийгмийн хариуцлага нь хамгийн түрүүнд авч үзэх буюу дэлхийн хэмжээний асуудал болоод байна. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) болон гүйцэтгэх удирдлагууд өөрсдийн бизнест чухал холбогдолтой асуудал болох байгаль орчин болон нийгмийн хариуцлагын асуудлыг хэрхэн тодорхойлох, нэгтгэх, хяналт тавих, тайлагнахад түлхүү анхаарна.

2. Компанийн зорилго, зорилтын ач холбогдол: Компанийн зорилго, оролцогч талуудын санал бодол нь хэдэн арван жилийн турш бизнесийн хэм хэмжээ болсоор ирсэн. Өнгөрсөн 8 дугаар сард АНУ-ын Business Roundtable холбооны 188 гишүүдийн 181 нь байгууллагын зорилгын талаар нэмэлт өөрчлөлт оруулсан мэдэгдэл бүхий баримт бичигт гарын үсэг зурсан бөгөөд хувьцаа эзэмшигчийн өгөөжийг хамгийн их байлгах гэсэн уламжлалт үзлийг хойш нь тавьжээ. Энэхүү бодлогын баримт бичигт бүх оролцогч талуудын эрхийг хангах нь илүү чухал зорилго гэж үзсэн байна. Үүнийг бүгд компаниуд практикт нэвтрүүлэхэд хүндрэлтэй, эргэлзээтэй боловч олон улс орны олон нийтийн санаа бодол хувьцаа эзэмшигчийн хэт давуу эрхийн эсрэг нэгэнт шилжээд байгаа юм.

3. Байгууллагын соёл, хүмүүн капиталын менежмент: Хөрөнгө оруулагчид эхний ээлжинд сөрөг өөрчлөлт, шинэчлэлийг давж чадахуйц бат бөх байгууллагын соёлыг бүрдүүлэх, байгууллагын соёл, хүмүүн капиталын менежментэд тавигдаж буй хяналттай холбоотой

үйл ажиллагаагаа ил тод байлгахыг ТУЗ-өөс хүсэж байна.

Компанийн стратеги, зорилгыг амжилттай хэрэгжүүлэхэд байгууллагын соёл мөн чадварлаг ажилтнуудтай байх хэрэгтэй тул энэ онд ажилд авах, ажилтнуудаа хадгалж үлдэх, тэдний бүтээмж зэрэгт байгууллагын соёл хэрхэн нөлөөлж буйг үнэлэх шаардлагатай.

4. ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн: Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэхийн хэрээр жендэрийн ялгаатай байдлыг шаардах болсон бөгөөд энэ хүрээнд олон алхмууд хийгдсэн байдаг. Энэ онд угсаа гарал, арьсны өнгө зэрэг олон төрөлжсөн байдалтай байх шаардлага үүсэж байна. Гэвч эдгээр нь улс орон бүрт харилцан адилгүй аж. Зарим оронд ТУЗ болон удирдлагын үндэс угсаа, арьсны өнгийн талаар мэдээллийг ил болгохыг шаарддаг ч энэ талаар мэдээлэл цуглуулах нь хууль бус эсвэл хатуу зохицуулалттай байдаг тул энэ хандлагыг дэлгэрүүлэх нь амар биш юм.

5. Компаниуд илүү өргөн хүрээний идэвхтэй байдалтай тулгарна: Дэлхий даяар хөрөнгө оруулагчдын идэвхжил хувьсан жилээс жилд өөрчлөгдөж буй хэв маяг, хандлагыг бий болгож байна. Зарим оронд уур амьсгалын эрсдэлтэй холбоотой хувьцаа эзэмшигчдийн хөдөлгөөн олон нийтийн анхаарлыг татаж, удирдлагын шийдвэр гаргалтад нөлөөлж байсан. Эдгээр нөхцөл байдалд бэлтгэхийн тулд ТУЗ-ийн үйл ажиллагаа, гишүүдэд тавигдах шаардлагыг өндөрсгөж замаар үр ашгаа дээшлүүлэх боломжтой.

Эх сурвалж: Харвардын Хуулийн сургуулийн компанийн засаглалын форум 2020



ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Үнэт цаасны зах зээлд нийт **530** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна.

Арилжаа эрхлэх 2	Төлбөр тооцооны 2	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн 1
ХОМК 25	Арилжаа эрхлэгчдийн холбоо 1	Кастодиан 3
Андерайтерийн зөвшөөрөлтэй банк 2	Хөрөнгө итгэмжлэн удирдах 4	ХК 305
ҮЦК 54	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх 1	ХАА түүхий эдийн брокер 14
ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх 60	ҮЦЗЗ-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 23	ҮЦЗЗ-д хуулийн үйлчилгээ үзүүлэх 33

*ҮЦК-д брокер, дилер, андерайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.




Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 хувиар өсөж 2.5 их наяд төгрөгт хүрсэн бол хөрвөх чадвар 1.4 пунктээр буурч 0.4 хувьд хүрлээ.
- Хөрвөх чадвар буурахад хувьцааны арилжааны хэмжээ 35.1 тэрбум төгрөгөөр буюу 4.7 дахин буурсан нь нөлөөлжээ.

Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП-20 Индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,948.6 нэгжээр буюу 18.9 хувиар буурсан.
- MSE А индекс өмнөх оны мөн үеэс 1,544.4 нэгжээр буюу 16.3 хувиар буурсан.
- MSE Б индекс өмнөх оны мөн үеэс 661.8 нэгжээр буюу 8.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. буюу 4.5 хувиар буурсан.







ХААБ-ээр нийт 28.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 4.9 тэрбум төгрөгөөр буюу 14.7 хувиар буурсан бөгөөд зөвхөн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжигджээ.



ХАА-н биржийн MAPIX индекс
 ХААБ-ээс тооцон гаргадаг Монголын хөдөө аж ахуйн индекс буюу MAPIX 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 794,438.0 нэгжид хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 291,371.5 нэгжээр буурсан байна.





1.2 ДААТГАЛЫН САЛБАР




ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

2020 оны 1 дүгээр улиралд даатгалын гүнзгийрэлт 0.44 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.01 хувиар буурсан байна.




* Давхар даатгалын зуучлагч давхардсан тоогоор орсон болно.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсөж, өмнөх улирлаас 4.3 хувиар буурч 350 тэрбум төгрөгт хүрлээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад 15.1 хувиар өсөж 286.4 тэрбум төгрөг хүрч, салбарын нийт хөрөнгийн 81.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.4 хувиар буурч, 54.1 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 15.5 хувийг эзэлж байна. 2020 оны 1 дүгээр улирлаас 1 давхар даатгалын компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор нийт хөрөнгийн өсөлт өмнөх үетэй харьцуулахад буурсан байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өсөж, 9.4 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.7 хувийг эзэлж байна.

- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж




НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 оны 1 дүгээр улиралд нийт 40.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 40.3 тэрбум төгрөг буюу 99.1 хувь, урт хугацааны даатгалын компани 0.4 тэрбум төгрөг буюу 0.9 хувийг бүрдүүлжээ.
- Нийт 13.1 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 0.8 тэрбум төгрөг буюу 5.9 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.
- 2020 оны 1 дүгээр улирлын ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.2 хувиар өсчээ.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР


- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 оны 1 дүгээр улиралд 15.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 24.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99.1 хувийг бүрдүүлжээ.
- Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 2.9 дахин өсөж 1.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.



1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


- 2020 оны 1 дүгээр улиралд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 540 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулав.
- Эдгээрийн 75 буюу 13.9 хувь нь орон нутагт, 465 буюу 86.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 5.2 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай, 94.8 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ

2020 оны 1 дүгээр улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 381.3 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар өсжээ.







НИЙТ ЗЭЭЛ

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар буюу 296.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Зээлийн хүү: 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.0 хувьд хүрч буурлаа.


2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 97.2 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 2.8 хувийг валютаар олгосон зээл эзлэж байна.



1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-ДЫН ТОО БА ГИШҮҮД

- 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо 254-т хүрч өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар буурлаа.
- ХЗХ-дын гишүүдийн тоо 2019 оны 1 дүгээр улиралд 66,296 байсан бол тайлант улиралд 12.7 хувиар өсөж 74,701-т хүрчээ.



АЖИЛЛАГСАД

810

ХЗХ-дын нийт ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.0 хувиар нэмэгдсэн бөгөөд түүний 73.1 хувь нь эмэгтэй

НИЙТ ГИШҮҮДИЙН

40,767


ЗЭЭЛДЭГЧ

38,066

ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ

НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар өсөж 229.5 тэрбум төгрөгт хүрлээ.
- Хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 23.2 пунктээр буурчээ.




ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

COVID-19-ийн дэлхийн ядууралд үзүүлэх нөлөөллийн тооцоо

2020 оны 4-р сард Дэлхийн банкны тооцоолсноор COVID-19 нь 40-өөс 60 саяын хүнийг ядуурал руу түлхэж байна гэж тооцоолсон. Одоогийн байдлаар тахлын голомт Европ, Хойд Америкаас дэлхийн өмнөд хэсэгт шилжжээ. Энэ нь бага болон дунд орлоготой улс орнуудад амь насаа алдах тохиолдлыг нэмэгдүүлж, карантиныг илүү уртасгаж, тахлын өвчний эдийн засагт үүсгэх зардлыг нэмэгдүүлж байна.

Дэлхийн эдийн засгийн 6-р сарын шинээр гарсан урьдчилсан мэдээг ашиглан дэлхийн улс орнуудын тахлын нөлөөнөөс үүсэх ядуурлыг тооцоолох боломжтой байна. Энэхүү урьдчилсан мэдээ нь суурь ба бууралт гэсэн хоёр хувилбарыг агуулж байгаа бөгөөд ингэснээр тахал нь ядууралд хэрхэн нөлөөлж болохыг хоёр өөр хувилбараар судлах боломжийг бидэнд олгосон юм. Суурь хувилбараар дэгдэлт одоогоор хүлээгдэж буй түвшинд хэвээр байгаа эсэх мөн үйл ажиллагаа энэ оны сүүлээр сэргэх эсэхийг үздэг бол бууралтын хувилбараар тархалт нь хүлээгдэж байснаас хэр удаан үргэлжилж, карантины арга хэмжээг хэр хугацаанд сунгах шаардлагатай болохыг хэмждэг. Бууралт хувилбар нь хэрэгжвэл эмзэг компаниуд (vulnerable firms) зах зээлээс гарах, эмзэг өрхүүд (vulnerable households) хэрэглээгээ эрс багасгаж, бага, дунд орлоготой хэд хэдэн улсын санхүүгийн дарамтыг нэмэгдүүлдэг. Суурь хувилбар нь 2020 онд дэлхийн өсөлт 5 орчим хувиар буурах төлөвийг үзүүлсэн бол бууралтын хувилбараар дэлхийн өсөлт нь 8 хувиар буурахаар байна.

Зураг. COVID-19-ийн дэлхийн хэт ядууралд үзүүлэх нөлөө



Эх сурвалж: Дэлхийн банк

- Хэт ядуурлыг өдөрт 1.90 доллараас доош зардлаар амьдардаг хүмүүсийн тоогоор хэмждэг.


COVID-19-ийн ядууралд үзүүлэх нөлөөллийг COVID-19 гарахаас өмнөх ДНБ-ий урьдчилсан таамаглалыг ашиглан гаргасан ядуурлын төсөөллийг COVID-19 гарсны дараах ДНБ-ий урьдчилсан таамаглалыг ашиглан гаргасан ядуурлын төсөөлөлтэй харьцуулж тооцно. Суурь хувилбарын дагуу бид COVID-19 нь 71 сая хүнийг өдөрт 1.90 доллараар хэмжигддэг ядуурлын туйлд хүргэж байна гэж тооцоолсон. Буурах хувилбараар энэ нь 100 сая болж нэмэгдсэн байна.

ГЕР-ийн урьдчилсан таамаглалаар дэлхийн эдийн засгийн өсөлт 2021 онд ойролцоогоор 4%-аар нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа ч, урьдчилсан таамаглалаар 2020-2021 оны хооронд хэт ядууралд амьдарч буй хүмүүсийн тоо ихээр өөрчлөгдөхгүй байна гэж үзэж байна. Хамгийн ядуу орнуудын эдийн засгийн өсөлтийн түвшнөөс маш их зүйл хамаарч байгаа юм. Нигери, Энэтхэг, Бүгд Найрамдах Ардчилсан Конго гэх гурван улсуудад дэлхийн ядуу хүмүүсийн гуравны нэгээс дээш хувь нь амьдардаг бөгөөд нэг хүнд ногдох ДНБ-ий бодит өсөлт нь харгалзан -0.8%, 2.1% ба 0.3% байна. Харин хүн амын өсөлт харгалзан 2.6%, 1.0% ба 3.1% байгаа нь ядуурлын түвшинг бууруулахад хангалттай биш юм.

Сахарын Африкт хамгийн хүнд цохилт болох магадлалтай гэж Дэлхийн банк таамаглажээ. Шинэ ГЕР-ийн урьдчилсан таамаглалаар дэлхийн олон ядуу хүмүүс байрлах Энэтхэг улсад энэ чиглэлээр илүү онцгой анхаарал хандуулж байна. Энэтхэгийн хамгийн сүүлийн үеийн ядуурлын тооцоо 2011-12 оны хооронд гарсан юм. Энэ хугацаа нь тахал эхлэхээс өмнөх ядуурлын талаар үнэн зөв ойлголт авахад хэцүү болгож байна.

Суурь хувилбарын дагуу 176 сая хүн 3.20 ам долларын ядуурлын шугам руу түлхэгдэж байгаагаас гуравны хоёр нь Өмнөд Азид байрладаг хүмүүс байна. Харин 5.50 ам.долларын ядуурлын шугамд орох төлөвтэй байгаа 177 сая хүн амын ихэнх нь Зүүн Ази, Номхон далайд, цөөн хэд нь Сахарын Африкт байна.

Зураг. COVID-19-т өдөөгдсөн ядуусын бүс нутгийн тархалт



Эх сурвалж: Дэлхийн банк

Жишээ нь Сахарын Африкт амьдардаг хэн нэгний өдөр тутмын орлого нь COVID-19-ийн үр дүнд 2.00 ам. доллараас 1.50 ам.доллар хүртэл буурч байвал тэд 3.20 ам.долларын шугамд биш харин 1.90 ам.долларын шугам дээр нэмэгдсэн хүн байна.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

Global Financial Centres Index /2020/

Centre	GFCI 27		GFCI 26		Change in	
	Rank	Rating	Rank	Rating	Rank	Rating
New York	1	769	1	790	0	▼21
London	2	742	2	773	0	▼31
Tokyo	3	741	6	757	▲3	▼16
Shanghai	4	740	5	761	▲1	▼21
Singapore	5	738	4	762	▼1	▼24
Hong Kong	6	737	3	771	▼3	▼34
Beijing	7	734	7	748	0	▼14
San Francisco	8	732	12	736	▲4	▼4
Geneva	9	729	26	706	▲17	▲23
Los Angeles	10	723	13	735	▲3	▼12
Shenzhen	11	722	9	739	▼2	▼17
Dubai	12	721	8	740	▼4	▼19
Frankfurt	13	720	15	733	▲2	▼13
Zurich	14	719	14	734	0	▼15
Paris	15	718	17	728	▲2	▼10
Chicago	16	717	16	732	0	▼15
Edinburgh	17	716	29	701	▲12	▲15
Luxembourg	18	715	25	708	▲7	▲7
Guangzhou	19	714	23	711	▲4	▲3
Sydney	20	713	10	738	▼10	▼25


Эх сурвалж: www.globalfinancialcentres.net



2020 оны 6 дугаар сарын 22-ны өдөр


S&P 500 /^GSPC/

3,097.74 +17.60 (-0.56%)




Nikkei 225 /^N225/

22,346.69 -132.10 (-0.59%)



FTSE 100 /^FTSE/

6,292.60 +68.53 (+1.10%)



Dubai Financial Market General Index DFMGI:IND

2,058.85 -19.53 /-0.94%/



Эх сурвалж: www.Bloomberg.com

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

+976-51-264444

press@frc.mn

www.frc.mn

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC_of_Mongolia